2026.09

126
ГИШҮҮНТЭЙ
АНХНЫ
ПАРЛАМЕНТЫН
2 ЖИЛ



МЭДЛЭГ, СУДАЛГААНД СУУРИЛСАН ШИЙДВЭР ГАРГАЛТ ДУТАГДАЖ БАЙНА...

Нацагдоржийн БАТСҮМБЭРЭЛ

Монгол Улсын Их Хурлын гишүүн, Улс төр судлаач, Ph.D

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ



Нацагдорж
БАТСҮМБЭРЭЛ

- Монгол Улсын Их Хурлын гишүүн
- УИХ дахь МАН-ын бүлгийн дэд дарга
- Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны гишүүн
- Эдийн засгийн байнгын хорооны гишүүн
- Аялал жуулчлалын хөгжлийн дэд хорооны дарга

ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЭЛТЭЙ ТАНИЛЦАНА УУ

batsumberel@parliament.mn

Нацагдоржийн Батсүмбэрэл

51266103

САНААЧИЛСАН ХУУЛЬ

- Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай
- Үндэсний их баяр наадмын тухай
- Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай
- Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай
- Хянан шалгах түр хороо байгуулах
- Тамхины хяналтын тухай хууль
- Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль
- Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай
- УИХ-ын хянан шалгах түр хороо байгуулах тухай
- Харьяатын тухай
- Онцгой албан татварын тухай
- Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай
- Цусны донорын тухай
- Хууль тогтоомжийн тухай
- Монгол Улсад хөдөлмөр эрхлэх гадаад ажилтны тоо, хувь хэмжээ тогтоохгүй байх, ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх тухай

АЖЛЫН ХЭСГИЙН ГИШҮҮН

- Хот байгуулалтын санал, дүгнэлт гаргах, холбогдох хууль тогтоомжийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг
- Хүнд эзлтэй, хүртээмжтэй орчин, тэгш оролцооны асуудлаар санал, дүгнэлт гаргах, холбогдох хууль тогтоомжийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг
- Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг
- Даатгалын хууль тогтоомжийн талаар санал, дүгнэлт гаргах, шаардлагатай бол холбогдох хууль тогтоомжийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг

ПАРЛАМЕНТЫН БҮЛЭГ

- Монгол-Унгарын парламентын бүлгийн дарга
- Монгол-Австрийн парламентын бүлгийн дарга
- Монгол-Туркменистаны парламентын бүлгийн гишүүн
- Монгол-Израилын парламентын бүлгийн гишүүн
- Монгол-Арабын Нэгдсэн Эмиратын парламентын бүлгийн гишүүн

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2026 ОНЫ ХАВРЫН ЧУУЛГАН

151 Нэгдсэн хуралдаан

234 Баталсан хууль

329 УИХ-ын тогтоол

2026-Иргэд, аж ахуйн нэгжийг дэмжсэн эрх зүйн шинэчлэлүүдийг хэрэгжүүлэв

1. Хувь хүний орлогын албан татварын тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай, Татварын ерөнхий хууль, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай, Онцгой албан татварын тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулаа.

2. Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийг батлан төр, хувийн хэвшлийн харилцааг тодорхой болгож, төр хувийн хэвшилтэй өрсөлдөхгүй, бизнесийн орчин тогтвортой, урьдчилан таамаглах боломжтой боллоо.

3. Гэр бүлийн тухай хуулийг 27 жилийн дараа шинэчлэн баталж, хүүхэд, эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах, олон хүүхэд төрүүлсэн эхчүүдийг ялгаварлалгүйгээр дэмжих эрх зүйн орчин бий болжээ.

Парламентын хяналт, ил тод байдлыг шинэ шатанд гаргав

4. И-Монголиа системд “Нээлттэй парламент” цэсийг нэвтрүүлснээр иргэд хууль тогтоомжийн төсөлд санал өгөх, нийтийн өргөдөл санаачлах, парламентын үйл ажиллагаанд цахимаар оролцох боломж бүрдсэн.

5. Монгол Улсын Ерөнхий сайд болон Засгийн газрын гишүүдтэй төрийн бодлого, шийдвэрийн хэрэгжилтийн талаар хэлэлцэх “Асуулгын цаг”-ийг гурван удаа зохион байгууллаа.

6. Parliament.mn цахим сайтыг шинэчилж, чуулган болон Байнгын хорооны хуралдааны тов, хэлэлцэх асуудал, танхим дахь гишүүдийн ирц, санал хураалтын дүн олон нийтэд нээлттэй болгосон юм.

2026 ОНЫ ХАВРЫН ЧУУЛГАНЫ ИРЦ



Н.Батсүмбэрэл

86% Ирсэн

3 Чөлөөтэй

4 Томилолт

0 Тасалсан

Эх сурвалж: uih.mn



ЯРИЛЦЛАГА

ШИЙДВЭР ГАРГАЛТ ТААМАГЛАЛ БУС МЭДЛЭГ, СУДАЛГААНД ҮНДЭСЛЭХ НЬ ХӨГЖИЛД ХҮРЭХ ХАМГИЙН ДӨТ ЗАМ

Нэг. ИРГЭН ТӨВТЭЙ, ТЭГШ БОЛОМЖИТ НИЙГМИЙГ БҮРДҮҮЛЭХ ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛ

Санаачилсан хууль

ЧУУЛГАНД ОРОЛЦОХ ГИШҮҮДИЙН САХИЛГА ХАРИУЦЛАГА ДЭЭШИЛНЭ 27х

НЭГ ХҮНИЙ ХАНДИВЛАСАН ЦУС ГУРВАН ХҮНИЙ АМИЙГ АВРАХ БОЛОМЖТОЙ 28х

НЭГ АМЬГҮЙ ДОНОР НАЙМАН ХҮНИЙ АМЬ НАСЫГ АВРАХ БОЛОМЖТОЙ 29х

ИРГЭДИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ЗОРИЛГООР СКҮҮТЕР, СУРРОНЫ ХЭРЭГЛЭЭГ ХУУЛЬЧИЛЛАА 30х

ГАДААДЫН САЙН ТАМИРЧДЫГ МОНГОЛ УЛСЫН ИРГЭН БОЛГОЁ 31х

ТЭТГЭВРИЙН МӨНГӨН ХУРИМТЛАЛ ҮҮСГЭХ БОЛОМЖ БҮРДЛЭЭ 32х

ПАРЛАМЕНТЫН БОДЛОГЫН ЗАЛГАМЖ ХАЛАА ТАСРАЛТГҮЙ ҮРГЭЛЖИЛНЭ 33х

УЛСЫН ИХ ХУРЛЫН ХЯНАН ШАЛГАХ ТҮР ХОРООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА ҮР ДҮНД ХҮРНЭ 34х

ХҮН ТӨВТЭЙ ХУУЛЬ ЗҮЙН БОДЛОГЫН СУУРЬ ТАВИГДАНА 35х

ЭЛЕКТРОН ТАМХИНЫ ЗОХИЦУУЛАЛТГҮЙ ХЭРЭГЛЭЭГ ХУУЛЬЧИЛЖ, ИРЭЭДҮЙ ҮЕЭ ХАМГААЛНА 36х

ХУУРАМЧ ШАТАХУУНЫ ЭСРЭГ ХУУЛИАР ИРГЭДИЙН ЭРҮҮЛ МЭНД, ЭД ХӨРӨНГИЙГ ХАМГААЛНА 37х

ОЮУ ТОЛГОЙН БАЯЛГААС ӨР ЗӨЭЛД ТӨЛӨХ БАЙСАН 22 ИХ НАЯД ТӨГРӨГИЙГ ХЭМНЭЖ ЧАДЛАА 38х

ХҮНСНИЙ ХАДГАЛАЛТ, ТЭЭВЭРЛЭЛТ, ХУДАЛДААНЫ АСУУДЛЫГ ХУУЛЬЧИЛЖ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТОГТОЛЦООГ САЙЖРУУЛНА 39х

ОРОН НУТГИЙН УДИРДЛАГЫН ТОМИЛГООГ ЗАСАГ ДАРГАД НЬ ШИЛЖҮҮЛЭХЭЭР ТӨСӨЛД ТУСГАЛАА 40х

Ажлын хэсгийн гишүүн

ЗӨВШӨӨРӨЛ НЭРТЭЙ ХОРИГЛОЛТ, ХҮНД СУРТЛААС ЧӨЛӨӨЛЖ ИРГЭДЭЭ ДЭМЖИНЭ 41х

ОЙ БОЛ ЗӨВХӨН МОД БИШ, НҮҮРСТӨРӨГЧ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, БИО-ЭДИЙН ЗАСГИЙН ШИНЭ БОЛОМЖ 42х

АГААРЫН ХӨЛӨГ, НИСЛЭГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ТОДОРХОЙ БОЛЛОО 43х

Байгуулын хороо

АЛБАНЫ НУУЦЫГ ХАЛЖ, 882 МЭДЭЭЛЭЛ ИЛ БОЛНО 46х

ИПОТЕКИЙН ЗЭЭЛИЙГ 8-14 ХУВИЙН ХҮҮТЭЙ ОЛГОЖ, ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛНЭ 47х

ТӨРӨӨС АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ХҮРТЭЭМЖ, ДЭД БҮТЭЦ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАРЫГ ЦОГЦООР ДЭМЖИНЭ 48х

БОЛОВСРОЛЫГ ДЭМЖИХ ЛОББИ БҮЛЭГТ НЭГДЛЭЭ 49х

КИБЕР АЮУЛГҮЙ БАЙДЛАА ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТҮВШИНД ХАМГААЛНА 50х



Монгол Ардын Нам

МОНГОЛ АРДЫН НАМЫН БҮЛГИЙН ДЭД ДАРГААР СОНГОГДЛОО 52х

“ГИШҮҮН ТӨВТЭЙ НАМ-Е4 СТРАТЕГИ” БОДЛОГЫН ХОРООГ АХЛАН АЖИЛЛАЖ БАЙНА 53х

“АРДЫН НАМ-АРД ТҮМЭНДЭЭ” АЯН БАЯНХОНГОР АЙМАГТ 54х

Гадаад харилцаа

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГ БОЛОН ЯЙЗУ ХОТЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ 8 ЖИЛ 56х

МОНГОЛ-АВСТРИЙН ПАРЛАМЕНТ ХООРОНДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА ШИНЭ ШАТАНД ГАРНА 57х

УНГАР УЛСТАЙ ХИЙХ ЭДИЙН ЗАСГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААГ ИДЭВХЖҮҮЛНЭ 58х

МОНГОЛ-КИРГИЗ ХОЁР ОРНЫ НАЙРАМДАЛТ ХАРИЛЦАА ШИНЭ ТҮВШИНД ХҮРНЭ 59х

Тойрог

УЛААНБААТАР ХОТЫН СОЁЛЫН ХУВЬСГАЛ “20 МИНУТЫН ХОТ” СЭЛБЭГ ДЭД ТӨВ 13х

23-Р СУРГУУЛЬ УСАН БАССЕЙН БҮХИЙ СПОРТ ЦОГЦОЛБОРТОЙ АНХНЫ УЛСЫН СУРГУУЛЬ БОЛЛОО 14х

108-Р ЦЭЦЭРЛЭГ ДАХИН ТӨЛӨВЛӨЛТӨД ОРЖ, ҮЙЛ АЖИЛЛАГАА 2 ДАХИН ӨРГӨЖЛӨӨ 15х

ОЛОН ТАЛТ ҮЙЛЧИЛГЭЭГ НЭГ ДОР ХҮРГЭХ “ЧИНГЭЛТЭЙН ЦОГЦОЛБОР-3” СОЁЛЫН ТӨВ НЭЭГДЛЭЭ 16х

“УНШДАГ ХҮҮХЭД ХӨГЖДӨГ” НОМ УНШЛАГЫН УРАЛДААН 3 ДАХЬ ЖИЛДЭЭ 17х

166 ДУГААР СУРГУУЛЬ АШИГЛАЛТАД ОРСНООР УЛСЫН СУРГУУЛИЙН ХҮРТЭЭМЖ НЭМЭГДЛЭЭ 18х

80 МЯНГАН ИРГЭНИЙ АМЬ НАС, ЭД ХӨРӨНГИЙГ ХАМГААЛАХ ГАЛ ТҮЙМЭР УНТРААХ, АВРАХ 86 ДУГААР АНГИ 19х

“ХҮСЭЛ МӨРӨӨДЛИЙН ТЭРГЭНЦЭР” ЭЗЭДДЭЭ ОЧЛОО 20х

ӨРХИЙН ЭМНЭЛГҮҮДИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖ САЙЖИРЛАА 21х

ЭРТ ИЛРҮҮЛЭГ, ОНОШИЛГООНЫ ТӨВТЭЙ БОЛОВ 22х

30 ГАРУЙ МЯНГАН ИРГЭН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭГ НЭГ ДОРООС АВАХ ЦЭГ БУЮУ СУХБААТАР АМБУЛАТОРИ 23х

НАРНЫ ХАВТАНГААС ЭРЧИМ ХҮЧ ГАРГАЖ, ДУЛААН ӨВӨЛЖСӨН САЙН ЖИШИГ ТОГТООЛОО 24х

БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН ШИНЭ ТҮНШЛЭЛ: БАЯНХОНГОР АЙМАГ БОЛОН ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГ 25х





ШИЙДВЭР ГАРГАЛТ ТААМАГЛАЛ БУС МЭДЛЭГ, СУДАЛГААНД ҮНДЭСЛЭХ НЬ ХӨГЖИЛД ХҮРЭХ ХАМГИЙН ДӨТ ЗАМ

УИХ-ын гишүүн Н.Батсүмбэрэл

Эрүүл мэнд, боловсрол 2 нь хүний амьдралын суурь багана, бие биенээ нөхөж байж утга төгөлдөр болдог тул төрөөс эн тэнцүү хөрөнгө оруулалт хийх нь улс орны болон ирээдүйн хөгжилд хамгийн чухал нөлөөтэй.

• 126 гишүүнтэй парламентын эхний 2 жилд таны санаачилсан эрүүл мэндийн чиглэлийн 2 хууль батлагдлаа. Эдгээр хуулиуд хэрэгжсэнээр монголчууд бидний амьдралд ямар өөрчлөлт, сэтгэл ханамж авчрах вэ?

Донорын тухай хууль анх 2000 онд батлагдаж, түүнээс хойш 5 удаа нэмэлт өөрчлөлт орсон ч цусны хангамж хийгээд эрхтэн, эд эс шилжүүлэн суулгах харилцааг 1 хуулиар бүрэн зохицуулж чадахгүй байв. Иймд салбарын урдаа барьдаг эмч гишүүн Ж.Чинбүрэн нарын гишүүдийн хамтаар өмнөх Донорын хуулийг хүчингүй болгож, оронд нь Цусны донорын тухай болон Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай 2 тусдаа хууль боловсруулж УИХ-аар батлууллаа.

Цөөн тооны донороо дэмжих, урамшуулах, тоог нь нэмэгдүүлэх, цаашлаад зөвхөн Улаанбаатар төдийгүй бүсчилсэн байдлаар цусны санг бүрдүүлэх хууль эрх зүйн орчны шинэчлэл уг хууль дээр тусгалаа оллоо. Монгол орны зүүн, баруун хязгаарт томоохон хэмжээний газар хөдлөлт болоход цусны нөөц, тээвэрлэлтийн хувьд бэлэн бус байгаа нь л хуулийн хэрэгцээ шаардлага ямар хэмжээнд хүрснийг илтгэнэ.

Манай улсад эд шилжүүлэн суулгах эмчилгээ, мэс ажилбарууд ид хийгдэж байна.

Монгол Улсад **210.000** бүртгэлтэй цусны донор бий.

46.000 байнгын идэвхтэй бөгөөд 100% сайн дурын үндсэн дээр цусаа бэлэглэдэг.

Цаашид зүрх, бөөр гэхчлэн гол эрхтнүүдийг шилжүүлэх чиглэлд үйл ажиллагаа өргөжих ёстой. Тиймээс эмнэлгийн зохион байгуулалтыг сайжруулах, процессыг илүү тодорхой болгох шаардлага үүссэн юм. Бидний сайн мэдэх П.Батчулуун эмчийн кэйс болоод насанд хүрээгүй хүүхдийн эрхтнийг эцэг, эх, ах дүүд нь дур мэдэн шилжүүлдэг байдал зэрэг нь уггаа зохицуулалтгүй байсны үр дагавар шүү дээ.

Харин хууль хэрэгжсэнээр хүүхэд эрхтнээ өгөхийг хүлээн зөвшөөрснөө бичгээр болон дүрсээр баталгаажуулах, донор болох эсэхээ өөрөө шийдэх, амьгүй донорын ар гэрт нөхөн төлбөр олгох, тээгч эхийн тусламжтайгаар үр хүүхэдтэй болж буй эцэг хүүхдээ мэндэлмэгц өөрийн нэрээр овоглох зэрэг олон асуудалд олон улсын жишгээр шийдэл гаргасан хууль болсныг онцолмоор байна.

“ ПАРЛАМЕНТЫН БАТАЛСАН ХУУЛИЙНХАА ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ ҮҮРГИЙГ УИХ-ЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТУХАЙ ХУУЛИАР АЛБАЖУУЛАХ НЬ ЗҮЙТЭЙ!

• Скүүтер, суррон, мопедын хэрэглээг хуульчилж, долдугаар сарын 1-нээс мөрдөж эхэллээ. Та хамтран өргөн барьсан гишүүний хувьд хууль хэрэгжих боломжийг хэрхэн харж байна вэ?

Энэ нь зөвхөн Улаанбаатар хотод зориулсан хууль биш. Хүн ам нь өсөн нэмэгдэж буй Дарханаас эхлэн аймгийн төвүүдэд хэрэгжүүлэх тал дээр анхаарна. Нэгэнт хийгдчихсэн зам дээр дээрх тээврийн хэрэгслүүдэд зориулсан зам бий болгох шаардлагатай болж байгаа. Энэ нь шинээр баригдах зам, байгууламжид баримтлах стандарт нь болох юм.

УИХ нь хууль хэрэгжүүлдэг бус хууль баталдаг байгууллага. Гэхдээ баталсан хуулийнхаа хэрэгжилтийг дүгнэх шаардлагатай болох нь эндээс харагдаж байна. Иймд УИХ-ын хяналт шалгалтын тухай хуулийг сайжруулж, энэ чиглэлийн нэмэлт, өөрчлөлт оруулахад анхаарч ажиллана.

Монгол Улсын хэмжээнд хэдэн хууль байна, тэдгээрт хэдэн удаа нэмэлт, өөрчлөлт орж нийгэм, эдийн засаг хийгээд ард түмний амьдралд үр өгөөжөө өгч байгааг судалж, дүгнэлт гаргадаг системийг загварчлахад анхаарч ажиллана.

• Та Чингэлтэй, Сүхбаатар дүүргээс сонгогдсон гишүүн. Нөгөөтэйгүүр, боловсрол, эрүүл мэндийн салбарын хөгжилд хөрөнгө оруулахыг чухалчилсаар ирсэн. Бодит үр дүн, онцлох ажлуудаасаа дурдвал?

Ерөнхий боловсролыг үнэ төлбөргүй эзэмших эрхийг Үндсэн хуулиар олгосон. Гэтэл өнөөдөр боловсролын хүртээмж хангалтгүй хэвээр байна.

Миний бие Чингэлтэй дүүргийн Засаг даргаар ажиллаж байх үед дүүргийн зарим иргэд 7-8 км, зарим нь 20-30 км-ийн зайнаас очиж төрийн үйлчилгээ авдаг байсныг хороодыг шинэчлэн зохион байгуулах замаар багасгах санаачилгыг ажил хэрэг болгож байлаа. Мөн шинээр сургууль барих ажлууд эрчимжсэн үе. Хамгийн сайн сургууль бол гэрт ойрхон сургууль гэдгийг бид бүгд хүлээн зөвшөөрнө.



Орон даяар 40-өөс дээш хүүхэдтэй 4860 бүлэгт **214,000** сурагч сурч буй бөгөөд үүнийг шийдэхийн тулд **108** сургууль, **95** цэцэрлэг шинээр барих шаардлагатай.

Эх сурвалж: "Боловсролын ерөнхий хуулийн хэрэгжилттэй танилцаж, санал дүгнэлт гаргах ажлын хэсгийн дүгнэлтээс.

Гагцхүү төр үүнийг бодлогоор дэмжих ёстой. Нэг сургууль барихын цаад талд боловсон хүчин, урсгал зардал, бүх талын хүртээмж гээд олон хүчин зүйлс бий бөгөөд цогцоор нь шийдэхийн тулд дахиад л эрх зүйн шинэчлэл шаардлагатай болж байгаа юм.

Мөн боловсролын чанарын асуудал буюу хүүхэд хаана амьдарч, ямар сургуульд сурч байгаагаас үл хамааруй, боловсролыг тэгш хүртэх ёстой. Материаллаг бааз, орчин, багш нарын цалингийн ялгаатай байдал арилж гэмээ нь асуудал шийдэгдэх юм.

"ЯАГААД 23 ДУГААР СУРГУУЛЬД ХҮҮХДЭЭ ОРУУЛАХЫН ТУЛД ТАНИЛ ТАЛ ХАЙХ ЁСТОЙ ЮМ! ЗАХ ХОРООЛЛЫН СУРГУУЛИУД ТӨВИЙНХӨӨС ЯАГААД ЯЛГААТАЙ БАЙХ ЁСТОЙ ГЭЖ!

Дүүргийн удирдлага байхдаа эхлүүлсэн томоохон ажил нь ЕБС-иудыг усан бассейнтай болгох явдал байв. Өнөөдөр 23-р сургууль олон улсын стандартад нийцсэн усан бассейнтай анхны улсын сургууль болсон. 37, 39-р сургуулиудад хийгдээд явж байна. Энэ яагаад чухал вэ гэхээр биеийн хөгжил, эрүүл ахуйн асуудлаас гадна сэтгэл ханамж гэдэг хүчин зүйлээр дамжуулж хүүхдэд маш олон эерэг үр дүн гарч болдог. Сургуульдаа идэвхтэй суралцах, ирэх дуртай болох, ингэснээр сурлагад нь ахиц гарах, цаашилбал ирээдүйд сайн боловсон хүчин болж бэлтгэгдэх юм. Боловсролын яамны энэ чиглэлд явуулж буй бодлого зөв.

Мөн улс орны баялаг, үнэт зүйл, хөгжлийн гол үндэс нь иргэн боловсролтой байхаас гадна эрүүл байх явдал юм. Энэ ч утгаараа дүүргийн өрхийн эрүүл мэндийн төвүүдийн байрны асуудлыг шийдэхээс гадна алслагдсан хорооны иргэдэд үзлэг хийх, яаралтай түргэн тусламжийн үйлчилгээ үзүүлэх зорилгоор гэр хорооллын 13 ӨЭМТ-д тээврийн хэрэгсэл олголоо.

Өрхийн эмнэлгүүд барилга объектын хувьд төрийн өмч юм шиг, зохион байгуулалтын хувьд хувийнх ч юм шиг ажиглагддаг. Анхан шатлалын эмнэлгээ



хувийн хэвшлүүдэд даатгадаг олон улсын жишиг ч бий. Хэн нь юу чадаж байгаа дээр үндэслэж эмчээ, эмнэлгээ сонгодог, тэнд нийгмийн даатгал нь үйлчилдэг ийм тогтолцоо руу орохын тулд 1-р шатлалын эмнэлгүүдээ хувийн хэвшилд өгчих нь оновчтой гэж хараад байгаа. Харин 2-р шатлалын эмнэлгүүдээ бэхжүүлэхэд төр анхаарлаа хандуулах нь чухал. СУИС-ийн дэргэдэх Чингэлтэй дүүргийн эмнэлэг бол оффисын зориулалттай барилга шүү дээ. Тэнд өргөтгөл бариад дуусаж байна. Хуучин байраа амбулаторийн зориулалтаар ашиглаад шинэдээ эмчилгээ, үйлчилгээгээ хийгээд явбал одоогийн нөхцөл байдал сайжрах нь дамжиггүй.

Мөн түүнчлэн шинжилгээ өгөхийн тулд хотын төв рүү түгжрэх, цаг алддаг байдал ард хоцорч, Чингэлтэйчүүд Хайлаастын Таван буудал орчимд Эрт илрүүлэг, оношилгооны төвтэй болоод 1 жил болж байна. 11 хороонд удаашралтай байгаа Амбулаторийн барилга, угсралтын ажлыг шахаж байна. Гэх мэтчилэн улсын төсвийн хөрөнгөөр эдгээр бүтээн байгуулалтаа хийчихэд оношилгоо, эмчилгээний бааз бэхжих юм.

Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр баригдах 3 эмнэлгийн нэг нь мөн Чингэлтэй дүүрэгт баригдана. Газар чөлөөлөлт хийгдсэн. Дэд бүтцийн ажил удаашралтай байгаа хэдий ч үргэлжилж байна. УИХ-ын гишүүний хувьд өрхийн эмнэлгийн зохион байгуулалтаас эхлэн шинэчлэл хийхээр эрүүл мэндийн 2 ч хуулийн Ажлын хэсэгт ажиллалаа.

“ ДУЛААН ОРНООС МОНГОЛ ОРНЫ ӨВЛИЙН УЛИРЛЫГ ЗОРИН ИРЭХ ЖУУЛЧИД РУУ ЧИГЛЭСЭН БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭГ БОДЛОГООР ДЭМЖИНЭ.

• Та УИХ-ын Аялал жуулчлалын хөгжлийн дэд хорооны даргаар томилогдсон. Өнгөрсөн хугацаанд энэ салбарын бодлого, үйл ажиллагаанд ямар ахиц гарав?

Мэргэжлийн байгууллагуудын үйл ажиллагаатай танилцлаа. Салбарын бодлогыг хэрхэн сайжруулах санал, зөвлөмжүүдийг боловсруулж холбогдох яам, байгууллагуудад хүргүүлсэн.

Онцолбол, мөнгөний эх үүсвэр гаргаад аялал жуулчлалын компаниудад 6 хувийн хүүтэй зээл олгож эхлээд байна. Бодлого хэрэгжих үед мэдээж асуудал гарна. Цаг тухай бүрт нь шийдээд явах нь л чухал.

Манай улсын аялал жуулчлал Евроазийн бүсэд маш чухал орон зайтай. Тур операторууд, баазууд, үйлчилгээний нарийн мэргэжлийн холбоодыг салбарын яам үйл ажиллагааны бодлого, чиглэлээр бүрэн дэмжиж байгаа юм билээ. Харин бид хууль, эрх зүйн таатай орчныг нь бүрдүүлж өгөх шаардлагатай байгаа.

Дотоодын аялал жуулчлалын төрлийг нэхмэгдүүлэх, үнийн тогтвортой байдлыг хангах, үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хялбаршуулахын зэрэгцээ чанарын асуудалд төрийн зүгээс онцгойлон анхаарах ёстой.



2026 оны эхний улирлын дүнгээр нийт

143,431

жуулчин ирсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад

39%

өссөн үзүүлэлттэй гарчээ.

Эх сурвалж: Нийслэлийн Аялал жуулчлалын газар

• Чингэлтэй, Сүхбаатар дүүрэгт эхлүүлсэн “Сэлбэ-Дэд төв”-ийн бүтээн байгуулалтын ажил санхүүжилтээс болоод зогсчихсон уу?

“Сэлбэ-Дэд төв” нь 158 га газрыг хамарч буй бөгөөд 8300 айл өрх шинэ орон сууцтай болохын зэрэгцээ хажуудаа сургууль, цэцэрлэгтэй, эмнэлэг, соёлын байгууллага, ногоон байгууламжтай болсноороо 20 минут дотор бүх үйлчилгээндээ хүрч, авдаг болох шинэ цагийн хотын зохион байгуулалт, хэв маяг руу орох, нөгөөтэйгүүр утаа, түгжрэл бууруулах оновчтой шийдэл мөн. Тиймээс “20 минутын хот” концепц үргэлжилнэ.

Ер нь бид мэдээлэл, таамаг дээр бус мэдлэг, судалгаан дээр үндэслэж шийдвэр гаргах ёстой шүү дээ. Үүнээс болж нийтээрээ төөрөгдөлд орчихдог. Гагцхүү бид дэлхийн хөгжилтэй хамт урагшлах уу, үгүй юу гэдэг асуудал эндээс л эхэлнэ.

• Ирэх намрын чуулганаас ямар хүлээлттэй байна, аль хуулиудад төвлөрч ажиллах вэ?

Олон нийтийн анхаарлын төвд буй Тамхины хяналтын тухай хуулийг санаачлагч гишүүний хувьд батлуулахын төлөө ажиллана. Мөн шинэ ордыг эргэлтэд оруулах, эрэл хайгуулыг дэмжих зохицуулалтыг Ашигт малтмалын тухай хуульд нэмж оруулах шаардлагатай. УИХ-ын гишүүний сахилга батыг сайжруулж, оролцоог нэмэгдүүлэх өөрчлөлтүүдийг хуулиуддаа тусгах нь ч мөн чухал байна.

Түүнчлэн МАН-ын бүлгийн дэд даргын хувьд эрх баригч намын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх, ЗГ-аас өргөн барьсан хуулиудыг батлуулах гээд олон асуудал руу орж ажиллана.

Ярилцсан: Б.Цэцэгсүрэн



ХӨГЖИЛД ХӨТӨЛСӨН ОНЦЛОХ АЖИЛ, БҮТЭЭН БАЙГУУЛАЛТУУД

- ДЭД БҮТЭЦ
- БОЛОВСРОЛ
- ЭРҮҮЛ МЭНД
- ЭРЧИМ ХҮЧ
- ХАМТЫН АЖИЛЛАГАА

УЛСЫН ТӨСӨВ 2026:
ЧИНГЭЛТЭЙ, СҮХБААТАР ДҮҮРЭГ

ЭРҮҮЛ МЭНД
3,63
ТЭРБУМ ТӨГРӨГ

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГ

Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн тоног төхөөрөмж
500.00 сая төгрөг

СҮХБААТАР ДҮҮРЭГ

Эрүүл мэндийн төвийн 1 дүгээр амбулатори, “Хавдрын эрт илрүүлгийн төв”-ийн тоног төхөөрөмж
1,000.00 сая төгрөг

Эмгэг судлалын үндэсний төвийн тоног төхөөрөмж
2,132.00 сая төгрөг

БОЛОВСРОЛ
19,87
ТЭРБУМ ТӨГРӨГ

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГ

Тусгай хэрэгцээт хүүхдийн цэцэрлэг /150 ор/
6,500.00 сая төгрөг

Залуу зохион бүтээгчдийн ордны барилга
4,500.00 сая төгрөг

Бага сургууль, цэцэрлэгийн цогцолборын барилга
3,000.00 сая төгрөг

СҮХБААТАР ДҮҮРЭГ

1-р сургуулийн өргөтгөл, шинэчлэл
3,566.30 сая төгрөг

“Google” хиймэл оюуны лаборатори сургуулийн тоног төхөөрөмж, сургалтын хэрэглэгдэхүүн
1,100.00 сая төгрөг

Кембрижийн хөтөлбөр хэрэгжүүлэх лаборатори сургуулийн тоног төхөөрөмж, сургалтын хэрэглэгдэхүүн /166-р сургууль/
1,200.00 сая төгрөг

БАРИЛГА, ДЭД БҮТЭЦ
9,85
ТЭРБУМ ТӨГРӨГ

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГ

Цагдаагийн 2-р хэлтсийн өргөтгөл
1,247.70 сая төгрөг

Цагдаагийн 59-р гудамжаас сурагчийн 47-р гудамж хүртэлх авто зам, гүүрэн байгууламж
1,400.00 сая төгрөг

СҮХБААТАР ДҮҮРЭГ

Майхан толгойн хатуу хучилттай авто зам
633.70 сая төгрөг

Хангайн 1-р гудамжаас Сэлбийн баруун эргийн далан хүртэлх авто зам
1,621.30 сая төгрөг

Цагдаагийн гудамжаас УБЦТС-ыг зүүн түгээх төвтэй холбох авто зам
2,092.00 сая төгрөг

Цагдаагийн гудамжны хойд талын хэвтээ тэнхлэгийн авто зам
1,610.40 сая төгрөг

УЛААНБААТАР ХОТЫН СОЁЛЫН ХУВЬСГАЛ **“20 МИНУТЫН ХОТ”** СЭЛБЭ ДЭД ТӨВ



Сэлбэ дэд төвийг түшиглэн гэр хорооллыг орон сууцжуулах төсөл Сүхбаатар дүүргийн 14, Чингэлтэй дүүргийн 14, 18 дугаар хороонд хэрэгжиж буй. Энэ хүрээнд Сэлбэ дэд төвийг барих газар чөлөөлөлтийг 2024 оны дөрөвдүгээр сард эхлүүлсэн.

Өнөөдрийн байдлаар эхний ээлжийн хоёр багц тендерийн бүтээн байгуулалт болох 8300 айлын орон сууцыг 6 буудал, Оргил худалдааны төв орчмын 25.6 га талбайд барих юм.

Сэлбийн бүтээн байгуулалт хийгдэж буй орчимд өнөөдөр ерөнхий боловсролын 3 сургууль хичээллэж байгаа. Үүн дээр нэмээд гадаад хэл, техник, спортын төрөлжсөн хөтөлбөртэй 3 сургууль, 5 цэцэрлэг шинээр барихаар төлөвлөөд байна.



Сэлбэ дэд төв бий болсноор:

- Стандартад нийцсэн 12 мянган айлын орон сууц баригдана.
- Иргэд 20 минутын дотор нийгмийн бүхий л үйлчилгээг авдаг болно.
- Хотын хэт төвлөрөл буурч, агаарын бохирдол 22% багасна.
- Хотын эдийн засаг тэлж, ажлын байр бий болох юм.



УИХ-ын гишүүн Н.БАТСҮМБЭРЭЛ:

Улаанбаатар хотод хийгдэж буй соёлын том хувьсгал юм. 4 уулын дунд 200 гаруй жил оршин буй нийслэл хот маань хамгийн бага хэсэгтээ л гэхэд 100 жилийн газрын элэгдэлтэй болчхоод байгаа. Айлыг олон удаа дулаалж чадахгүй. Утаа, үер, ус, түлш, дулаан гээд бүх асуудлыг ганц замаар л шийднэ. Энэ бол барилгажилт.




Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч асан Х.НЯМБААТАР:

Сэлбийн бүтээн байгуулалт III, IV хороолол дээр “Өнөр” хорооллыг нэмсэн дайны том бүтээн байгуулалт болно. Өөрөөр хэлбэл нийтдээ 13 мянган айлын үйлчилгээтэй орон сууцны цогц төсөл болох юм. Бид энэ ажлыг 24 сарын хугацаанд барьж дуусгана.



23-Р СУРГУУЛЬ **УСАН БАССЕЙН БҮХИЙ СПОРТ ЦОГЦОЛБОРТОЙ** АНХНЫ УЛСЫН СУРГУУЛЬ БОЛЛОО





Нийслэлийн Ерөнхий боловсролын 23 дугаар сургуулийн олон улсын стандартад нийцсэн, усан бассейн бүхий спорт цогцолбор 2026 оны 3-р сарын 4-ний өдөр нээлтээ хийж, ашиглалтад орлоо.

Энэхүү цогцолбор нь 2448 м.кв талбай бүхий 2 давхар байгууламжтай бөгөөд доргио шингээгч шал, акустик ханатай, аюулгүй байдлыг бүрэн хангасан спорт заалтай гэдгээрээ онцлогтой юм. 3100 сурагч, 150 гаруй багш, ажилчид тохилог орчинд хичээллэх боломж ийнхүү бүрдэж байна.



УИХ-ын гишүүн Н.БАТСҮМБЭРЭЛ:

Спорт цогцолборын нээлт дээр сурагчдынхаа баярласан төрхийг харахад үнэхээр сайхан байлаа.”Нэг сургууль-Нэг стандарт” зарчмаар дүүргийнхээ бүх сургуулиудыг ийм жишигт хүргэхийн төлөө бид ажиллаж байна. Манай дүүргийн сургуулиуд зөвхөн мэдлэг олгоод зогсохгүй, хүүхдийн авьяас чадвар, бие бялдрыг хөгжүүлэх иж бүрэн төв болж өөрчлөгдөж байна.



Чингэлтэй дүүргийн Засаг дарга Н.МАНДУУЛ:

Чингэлтэй дүүргийн 37 болон 39 дүгээр сургуулиудад мөн адил ийм спорт цогцолборууд баригдаж байгаа бөгөөд удахгүй ашиглалтад орохоор төлөвлөгдөж байна. Энэ нь манай дүүргийн хүүхэд багачуудын эрүүл мэнд, бие бялдрын хөгжилд оруулах бодит хөрөнгө оруулалт юм.



108-Р ЦЭЦЭРЛЭГ ДАХИН ТӨЛӨВЛӨЛТӨД ОРЖ, ҮЙЛ АЖИЛЛАГАА **2 ДАХИН ӨРГӨЖЛӨӨ**

Чингэлтэй дүүргийн 6 дугаар хороонд 240 ортой цэцэрлэгийн шинэ барилгыг 2025 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр Улсын комисс хүлээн авснаар ашиглалтад орлоо.

Барилгын насжилт хэтэрсэн цэцэрлэгийн барилгыг дахин төлөвлөлтөд хамруулж, стандартад нийцүүлэн шинэчлэн засварласнаар 4 бүлэгтэйгээр үйл ажиллагаа явуулж байсан бол хамран сургах тойргийн хүүхдийн хэрэгцээ, эрэлтэд нийцүүлэн 10 бүлэг болгон нэмэгдүүлэв.

Түүнчлэн бүлгийн өрөө, чийрэгжүүлэх болон дуу хөгжмийн өрөө, гал тогоо, хуурай, нойтон хүнсний агуулах, ажилчдын хувцас солих өрөө, эд хогшлын агуулах зэрэг зориулалтын олон өрөө тасалгаатай болжээ.





“ ТУС ЦЭЦЭРЛЭГ НЬ ТЭНХЛЭГЭЭРЭЭ 47Х24 МЕТР ХЭМЖЭЭТЭЙ, ХАГАС ЗООРЬТОЙ, 2 ДАВХАР, НИЙТ 2857 М.КВ ТАЛБАЙ БҮХИЙ БАРИЛГА ЮМ.





ОЛОН ТАЛТ ҮЙЛЧИЛГЭЭГ НЭГ ДОР ХҮРГЭХ **“ЧИНГЭЛТЭЙН ЦОГЦОЛБОР-3”** СОЁЛЫН ТӨВ НЭЭГДЛЭЭ

ЧД-ийн 14 дүгээр хороонд байрлах 1554 м^2 талбай бүхий “Чингэлтэйн цогцолбор-3” барилга ашиглалтад орж, дүүргийн Соёлын төв 2026 оны тавдугаар сарын 6-ны өдөр өндөр үүдээ нээлээ. Тус цогцолбор нь хүүхэд, залуучууд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд соёл урлаг, спорт, боловсрол, эрүүл мэндийн олон талт үйлчилгээг нэг дор хүргэх зорилготой бүтээн байгуулалт юм.



“УРЛАГ, СОЁЛЫН НЭГДСЭН АРГА ХЭМЖЭЭНҮҮД НЬ ИРГЭДИЙН ХАРИЛЦАН ОЙЛГОЛЦЛЫГ ГҮНЗГИЙРҮҮЛЖ, НИЙГМИЙН СТРЕССИЙГ БУУРУУЛАХ ЭРЭГ НӨЛӨӨТЭЙ ТУЛ ТӨР БОДЛОГООР ДЭМЖИХ НЬ ЗҮЙН ХЭРЭГ.



УИХ-ын гишүүн Н.БАТСҮМБЭРЭЛ:

“Чингэлтэй дүүргийн Засаг даргаар ажиллах хугацаандаа “Хайрхан хөгжлийн төв-2”, “Хайрхан хөгжлийн төв-3” цогцолборын төлөвлөлт, төсөв, хэрэгжилтийг урагшлуулахад анхаарч ажилласан. Энэ ажил маань үргэлжилж, иргэдэд бодит үйлчилгээ болон хүрч байгааг харахад сэтгэл хангалуун байна. Цаашид ч иргэдийн эрүүл, идэвхтэй, соёлтой амьдралын хэв маягийг дэмжсэн бүтээн байгуулалтуудыг дэмжих болно.



“УНШДАГ ХҮҮХЭД ХӨГЖДӨГ” НОМ УНШЛАГЫН УРАЛДААН 3 ДАХЬ ЖИЛДЭЭ

Их Монгол Улс байгуулагдсаны түүхт 820 жилийн ойг тохиолдуулан “Түүхээ мэдье, түгээн дэлгэрүүлье” уриан дор Уншдаг хүүхэд хөгждөг ном уншлагын уралдаанаа 3 дахь жилдээ зохион байгууллаа. Энэхүү уралдаан нь сурагчдад эх түүхээ таниулах, түгээн дэлгэрүүлэх, сурталчлах, мэдлэг, ойлголтыг нь гүнзгийрүүлэх, эх оронч үзлийг төлөвшүүлэхэд чиглэж буй зорилгоо амжилттай хэрэгжүүлж, нийгэмд томоохон давалгааг бий болгож чадсан юм.

> **ЭНЭ УДААГИЙН УРАЛДААНД НИЙТ 2500 ОРЧИМ ХҮҮХЭД НЭГДЭЖ, ЭХ ТҮҮХЭЭ ШИМТЭН УНШСАНААС 114 БҮТЭЭЛЧ КОНТЕНТ БЭЛТГЭН ИРҮҮЛСЭН БӨГӨӨД ЭДГЭЭР БҮТЭЭЛ ЦАХИМ ОРЧИНД ДАВХАРДСАН ТООГООР 1 САЯ ХҮНД ХҮРЧЭЭ.**



ҮГИЙН БАЯЛАГ НЭМЭГДЭНЭ
Сэтгэн бодох, өөрийгөө илэрхийлэх чадвар сайжирна.

ТӨСӨӨЛӨН БОДОХ ЧАДВАР ТЭЛНЭ
Номын үйл явдлыг тархиндаа дүрсэлснээр бүтээлч сэтгэлгээ хөгждөг.

АНХААРАЛ ТӨВЛӨРӨЛТ САЙЖИРНА
Урт бичвэр уншиж сурснаар сууж сурах, тууштай байх чадвар сууна.

ЭМПАТИ БУЮУ БУСДЫГ ОЙЛГОХ ЧАДВАР НЭМЭГДЭНЭ
Зохиолын баатруудын мэдрэмжийг хуваалцсанаар бусдыг хайрлах, ойлгох ухаан суудаг.









166 ДУГААР СУРГУУЛЬ АШИГЛАЛТАД ОРСНООР **УЛСЫН СУРГУУЛИЙН ХҮРТЭЭМЖ** НЭМЭГДЛЭЭ

Сүхбаатар дүүргийн 12 дугаар хороонд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр баригдсан 720 хүүхдийн суудалтай Ерөнхий боловсролын 166 дугаар сургууль 2025 оны 4-р сарын 15-нд албан ёсоор ашиглалтад орсон.

Тус хороо нь улсын сургуульгүй бөгөөд энэхүү сургууль ашиглалтад орснoор 32-ын тойрог орчмын 1500 орчим хүүхэд тав тухтай сурч боловсрох боломжтой болж байна. Хамран сургах тойргийн дагуу дүүргийн XI, XII, XIII хорооны хүүхдүүд суралцах бөгөөд өнөөдрийн байдлаар 150 сурагч, 25 багш, ажилтантайгаар үйл ажиллагаагаа эхлүүлээд байна.

Дөрвөн блок бүхий зоорьтой, гурван давхар барилгад анги танхим, эрхлэгчийн өрөө, нягтлан, нийгмийн ажилтны өрөө, хурлын танхим, багш нарын өрөө, дуу хөгжмийн кабинет, соёлын танхим, спорт заал, дугуйлангийн өрөөнөөс бүрдэх энэхүү сургуульд дулаан хангамжаа хийн баллонт зуухнаас авах иж бүрэн төхөөрөмж суурилагдсан байна.

> **СҮХБААТАР ДҮҮРЭГТ ТӨРИЙН ӨМЧИЙН 27 ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛДАГ БӨГӨӨД ДҮҮРГИЙН ХЭМЖЭЭНД НИЙТ 47,951 СУРАГЧ СУРАЛЦАЖ БАЙНА.**







> **МОНГОЛ УЛСЫН ХЭМЖЭЭНД ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬЯА 80 ГАРУЙ ГАЛ ТҮЙМЭР УНТРААХ, АВРАХ АНГИ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙНА.**

80 МЯНГАН ИРГЭНИЙ АМЬ НАС, ЭД ХӨРӨНГИЙГ ХАМГААЛАХ ГАЛ ТҮЙМЭР УНТРААХ, АВРАХ 86 ДУГААР АНГИ

УИХ-ын гишүүн Н.Батсүмбэрэл Чингэлтэй дүүргийн Засаг даргаар ажиллах хугацаандаа дүүргийн иргэдийн аюулгүй байдлыг хангах, ялангуяа гэр хорооллын бүсэд гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх асуудлыг нэн тэргүүнд тавьж ажилласан байдаг.

Дүүргийн ИТХ, ЗДТГ, Онцгой байдлын хэлтэс болон гүйцэтгэгч “Дуутын нуруу” ХХК-ийн хамтын хичээл зүтгэлийн үр дүнд нэг жилийн хугацаанд орчин үеийн олон улсын шаардлагад нийцсэн 3 давхар, төмөр бетон бүтэцтэй, 2132 м^2 талбай бүхий цогц байгууламж 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр ашиглалтад орсон. Нийслэлийн хэмжээнд гал түймрийн дуудлагын 70–80 хувь нь гэр хорооллын бүсэд бүртгэгддэг ч замын ачаалал, хаягийн зөрчлөөс үүдэн аврагчид цаг алдах эрсдэлтэй байдаг.



Тус анги ашиглалтад орсноор Чингэлтэй дүүрэг төдийгүй нийслэлийн хойд чиглэлийн бүсэд гамшгаас хамгаалах төрийн үйлчилгээг илүү ойроос, илүү шуурхай хүргэж, 80,000 гаруй иргэний амь нас, эд хөрөнгийг авран хамгаалах нөхцөл бүрэн хангагдаж байна.



УИХ-ын гишүүн Н.БАТСҮМБЭРЭЛ:

Төр засаг, ард түмнийхээ итгэл найдварыг хүлээж, бусдын төлөө амиа өгөхөөс буцдаггүй эрэлхэг залуус энх цагийн эх орончдоороо Монгол төр цаг ямагт бахархдаг. Тиймээс аврагч, гал сөнөөгчид маань хамгийн сүүлийн үеийн техник хэрэгсэл, багаж, тоног төхөөрөмжтэй, дулаан, тохилог орчинд ажиллаж амьдрах ёстой.

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭД ЧУУЛЖ, ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДЛАА ХЭЛЭЛЦЛЭЭ

2025.11.04 - Чингэлтэй дүүргийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн чуулга уулзалтыг УИХ-ын гишүүн Н.Батсүмбэрэлийн ивээл дор зохион байгуулсан юм. Энэ үеэр ОУ-ын “Хүсэл мөрөөдлийн тэргэнцэр” байгууллагаас илгээсэн 50 тэргэнцрийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд гардуулан өгөв.



20 ХҮҮХДЭД ТЭРГЭНЦЭР ГАРДУУЛЛАА

2026.01.31 - Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн хөдөлгөөний боломж, сурч боловсрох эрх, нийгмийн оролцоо бол тусламжийн асуудал биш — тэгш эрх, бодлогын асуудал юм.
Иймээс “Хүртээмжтэй ирээдүй” санаачилгын хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй 20 хүүхдэд зориулалтын тэргэнцэр гардууллаа.





МОНГОЛ УЛСАД 2024 ОНЫ ТООН МЭДЭЭГЭЭР

14,609

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХЭД БИЙ.

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГТ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ТОО

3,316

БӨГӨӨД ТЭДГЭЭРИЙН 0–17 НАСНЫ ХҮҮХЭД

455

БҮРТГЭГДСЭН БАЙНА.

“

ХӨДӨЛГӨӨНИЙ БОЛОМЖ, СУРЧ БОЛОВСРОХ ЭРХ, ЭРҮҮЛ МЭНД, СЭРГЭЭН ЗАСАХ ҮЙЛЧИЛГЭЭ, ГЭР БҮЛИЙН ДЭМЖЛЭГ, ОЛОН НИЙТИЙН ОРЧИНД ЧӨЛӨӨТЭЙ ОРОЛЦОХ НӨХЦӨЛИЙГ ТОГТОЛЦООГООР САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ.



ӨРХИЙН ЭМНЭЛГҮҮДИЙН **ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖ** САЙЖИРЛАА

Чингэлтэй дүүргийн иргэдэд эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээг илүү шуурхай, хүртээмжтэй хүргэх зорилгоор дүүргийн 13 өрхийн эрүүл мэндийн төвд суудлын автомашин нийлүүллээ.

Манай дүүрэг хүн амын төвлөрөл ихтэй, гэр хорооллын бүс өргөнтэй тул өрхийн эмнэлгүүдийн гэрийн эргэлт, яаралтай дуудлагын бэлэн байдлыг сайжруулах нь иргэдийн эрүүл мэндийн үйлчилгээнд шууд нөлөөлөх чухал асуудал юм.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шийдвэрлэсэн энэхүү автомашинуудыг УИХ-ын гишүүн, УИХ дахь МАН-ын бүлгийн дэд дарга Н.Батсүмбэрэл, УИХ-ын гишүүн Ц.Баатархүү, ЭМЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Н.Эрдэнэбаяр, Чингэлтэй дүүргийн Нэгдсэн эмнэлгийн захирал Х.Ганцэцэг нар ӨЭМТ-үүдийн удирдлагуудад гардуулан өглөө.

Шинэ автомашинууд ашиглалтад орсноор өрхийн эмч, мэргэжилтнүүд иргэдийн гэрээр үзүүлэх тусламж, яаралтай дуудлага, анхан шатны үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх боломж бүрдэж байна.

> **“ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГТ НИЙТ 13 ӨРХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА БӨГӨӨД ДУНДЖААР НЭГ ЭМНЭЛЭГ НЬ 10,000 ОРЧИМ ИРГЭНД ЭМНЭЛГИЙН АНХАН ШАТНЫ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭГ ҮЗҮҮЛДЭГ.**







ЭРТ ИЛРҮҮЛЭГ, **ОНОШИЛГООНЫ ТӨВТЭЙ** БОЛОВ

Иргэдэд ерөнхий шинжилгээ, хавдар, бамбай, дотрын, хүүхдийн гэх мэт 20 багц шинжилгээг хийх Эрт илрүүлэг, оношилгооны төв 2026 оны босгон дээр нээлтээ хийсэн.
Тус төв нь хоёр давхар, нийт 1431.6 ам метр талбайтай бөгөөд 2025 оны хамгийн сүүлийн үеийн тоног төхөөрөмжөөр тоноглогджээ.


2023 оны 9 дүгээр сараас барьж эхэлсэн бөгөөд дэд бүтцийн хамт нийт өртөг 6.4 тэрбум төгрөг аж. Чингэлтэй дүүрэг 24 хороотой бөгөөд үүний 70 гаруй хувь нь гэр хороолол юм. Эдгээр иргэд “Сонгодо”, “Интермэд” зэрэг эмнэлгээс авдаг үйлчилгээг гэрийнхээ хаяанаас авах боломж ийнхүү бүрджээ.



УИХ-ын гишүүн Н.БАТСҮМБЭРЭЛ:

Энэхүү төвийг дүүргийн 14 дүгээр хороо буюу 5 буудалд барьж, ашиглалтад оруулж байгаа нь онцлог бөгөөд “20 минутын хот” концепцтэй уялдуулж байгаа хэлбэр. Чингэлтэй дүүргийн 14, 18 дугаар хороонд дахин төлөвлөлт эрчимтэй хийгдэж буй. Одоогийн байдлаар 18 дугаар хороонд газар чөлөөлөлт 80 хувьтай байна. Ирэх онд 14 хороонд газар чөлөөлөлт энэ хэмжээнд үргэлжилнэ.







Тус төв нь дүүргийн урд бүсийн 30 гаруй мянган иргэнд амбулаторийн 15 төрөлжсөн мэргэжлийн эмчийн үзлэг, 17 төрлийн оношилгоо, 5 төрлийн лабораторийн шинжилгээ болон яаралтай тусламжийг үзүүлж эхлээд байна.


30 ГАРУЙ МЯНГАН ИРГЭН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭГ НЭГ ДОРООС АВАХ ЦЭГ БУЮУ СҮХБААТАР АМБУЛАТОРИ

Сүхбаатар дүүргийн Эрүүл мэндийн төвийн харьяа Салбар Амбулатори-1 буюу “Эрүүл мэндийг дэмжих төв”-ийн шинэ барилга 2026 оны зургаадугаар сарын 30-ны өдөр ашиглалтад орлоо.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 1957 оны хуучин хоёр давхар барилгыг буулгаж, орчин үеийн стандартын шаардлагад нийцсэн 5 давхар, 2,119.5 м^2 талбай бүхий шинэ эмнэлгийг ашиглалтад оруулсан нь энэ юм.









Монгол Улсын Ерөнхий сайд Н.УЧРАЛ:

Олон хүний хичээл зүтгэлээр хоёр дахин их хүчин чадалтай эмнэлэг ашиглалтад орсонд баяртай байна. Шинэ эмнэлэг иргэдэд эмнэлгийн тусламж үйлчилгээг тогтмол үзүүлэхэд Засгийн газар бүрэн дэмжлэг үзүүлж, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангана.



Эрүүл мэндийн сайд Э.БАТШУГАР:

Шинэ эмнэлэг зөвхөн эмчилгээ хийдэг газар биш, иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, өвчнөөс урьдчилан сэргийлэх төв байх ёстой. Анхан шатны тусламж үйлчилгээг бэхжүүлж, дижитал шилжилт, хиймэл оюуны хэрэглээг эрчимжүүлэх нь эрүүл мэндийн салбарын шинэчлэлийн гол чиглэл юм.



НАРНЫ ХАВТАНГААС **ЭРЧИМ ХҮЧ** ГАРГАЖ, ДУЛААН ӨВӨЛЖСӨН САЙН ЖИШИГ ТОГТООЛОО

Улаанбаатарын эрчим хүчний хомсдолыг шийдэх гарц нь сэргээгдэх эрчим хүч. Өвөл болохоор л тог хязгаарладаг, иргэдийг хүндрэлд оруулдаг байдлыг халах хамгийн бодит бөгөөд хурдан шийдэл бол сэргээгдэх эрчим хүчний шилжилт юм.

2025-2026 оны өвөл Чингэлтэй дүүргийн 93 айлд нарны панель суурилуулснаар эдгээр өрхүүд тог тасрах айдасгүй, гэрэлтэй, дулаан өвөлжсөн сайн жишиг тогтлоо. Улаанбаатар хотын гэр хорооллын 220 мянган айл өрхийг ийм байдлаар нарны панельтай болгох нь эрчим хүчний хүнд суртлаас ангижрах, дулааны алдагдлаас сэргийлэх хамгийн зөв гарц болоод байна.

МОНГОЛ УЛС БОДЛОГЫН ТҮВШИНД
- **НАР**
- **САЛХИ**
- **БАТАРЕЙ**

ХУРИМТЛУУР
- **ГИБРИД**


СИСТЕМИЙГ АШИГЛАХ, ХОСОЛСОН ШИЙДЭЛ РҮҮ ШИЛЖИХ ШААРДЛАГАТАЙ ТАЛААР ИД ЯРИГДАЖ БАЙНА.



Чингэлтэй дүүргийн Засаг дарга Н.МАНДУУЛ:

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөртэй хамтарч дулаан, эрчим хүчийг нарны энергиэс гарган авдаг системийг айл өрхүүдэд 2 өвөл туршихад -40 хэмийн хүйтнийг хязгаарлалтад оролгүй давж чадлаа. Иргэд ч ам сайтай байна. Амьдралд тустай, сайн туршлагыг цаашид өргөжүүлэх нь чухал учраас зах зээлийн бүтээгдэхүүн болгох тал дээр арилжааны банкуудтай хамтран ажиллахаар яриа хэлэлцээний түвшиндээ явж байна.







БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН ШИНЭ ТҮНШЛЭЛ: **БАЯНХОНГОР АЙМАГ БОЛОН ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГ**

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050” болон “Шинэ сэргэлтийн бодлого”-д тусгагдсан хот, хөдөөгийн хөгжлийн тэнцвэрийг хангах зорилтын хүрээнд Чингэлтэй дүүрэг болон Баянхонгор аймгийн хамтын ажиллагаа шинэ шатанд гарч байна.

Ногоон хөгжил, инновацад суурилсан хот байгуулалт, байгальд ээлтэй технологийг нэвтрүүлэхэд хамтран ажиллаж, сэргээгдэх эрчим хүчийг дэмжих, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, агаарын бохирдлыг бууруулах бодит төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхийг тусгасан хамтын ажиллагааны “Санамж бичиг”-ийг өнгөрөгч хоёрдугаар сарын 26-ны өдөр байгууллаа.

Мөн боловсрол, соёл, эрүүл мэндийн салбарт харилцан туршлага солилцож, хамтарсан сургалт, семинар зохион байгуулах, төрийн албан хаагчдын мэргэжлийн чадавхыг дээшлүүлэх, иргэдэд чиглэсэн үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулахад анхаарах аж.



Баянхонгор аймгийн Засаг дарга Э.ЭНХБАТ:

Орон нутгийн эдийн засгийг дэмжих хүрээнд бичил, жижиг, дунд үйлдвэрлэл, хоршоо, иргэдийн бизнесийн санаачилгыг дэмжих, орон нутгийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалтыг нэмэгдүүлэх чиглэлээр хамтарсан арга хэмжээ хэрэгжүүлэхээр тохиролцлоо.

ТҮНШЛЭЛИЙН ҮНДСЭН 3 ТУЛГУУР

- **НОГООН ХӨГЖЛИЙН ШИЛЖИЛТ:** Уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй хот байгуулалт, сэргээгдэх эрчим хүчний шийдлүүдийг нэвтрүүлж, агаарын бохирдлыг бууруулах бодит төслүүдийг хамтран хэрэгжүүлнэ.
- **ХҮНИЙ НӨӨЦИЙГ ЧАДАВХЖУУЛАХ:** Боловсрол, эрүүл мэндийн салбарын туршлага солилцоог идэвхжүүлж, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг ижил түвшинд хүргэх замаар иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлнэ.
- **ЭДИЙН ЗАСГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА:** Орон нутгийн баялаг, үйлдвэрлэлийг нийслэлийн зах зээлтэй холбох, ЖДҮ эрхлэгчдийн нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний борлуулалтыг дэмжих замаар эдийн засгийн бодит үр өгөөжийг бүрдүүлнэ.



ИРГЭН ТӨВТЭЙ, ТЭГШ БОЛОМЖИТ НИЙГМИЙГ БҮРДҮҮЛЭХ ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛ

САНААЧИЛСАН ХУУЛЬ

АЖЛЫН ХЭСЭГ

БАЙНГЫН ХОРОО

БАЙР СУУРЬ

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай
Батлагдсан огноо: 2026.07.02

ЧУУЛГАНД ОРОЛЦОХ ГИШҮҮДИЙН САХИЛГА ХАРИУЦЛАГА ДЭЭШИЛНЭ

УИХ-ын үйл ажиллагаа төлөвлөлттэй, хэлэлцүүлгийн дэг оновчтой, чуулганы үйл ажиллагаанд оролцож байгаа гишүүд, бусад албан тушаалтнуудын үүрэг тодорхой, хариуцлагатай байх чиглэлээр уг хуулийн төслийг боловсруулжээ.



Хуулийн төсөлд:

- Хууль санаачлагчийн өргөн мэдүүлсэн хуулийн төслийг тодорхой хугацааны дотор хэлэлцэх асуудлын тов, дараалалд тусгах,

- Хуралдааны явцад асуулт, хариултыг үр дүнтэй зохион байгуулах,

- Хууль тогтоомжийн төслийг хэлэлцэхэд мэтгэлцээн зохион байгуулах,

- Төслийг яаралтай хэлэлцүүлэх үндэслэл, шаардлагын талаар хууль санаачлагчийн танилцуулгыг сонссоны дараа шийдвэрлэх,

- Хуулийн төсөлд хууль зүйн дүгнэлт гаргах хүрээг тогтоох,

- Хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийн үр нөлөөг дээшлүүлэх талаар төсөлд тусгалаа.



УИХ-ын гишүүн Ж.БАТ-ЭРДЭНЭ:


УИХ-ын чуулганы хуралдаанд санал хураалттай холбоотойгоор гишүүдийн хариуцлагыг сайжруулах хүрээнд хүндэтгэн үзэх шалтгаантай бол шалтгаан, үндэслэлээ хуралдааны өмнөх өдөр бичгээр мэдэгдэх, хүндэтгэх шалтгаангүйгээр санал хураалтад оролцоогүй, хуралдааныг орхин гарсан бол эсрэг санал өгсөнд тооцох зохицуулалтыг хасаж, санал хураалтад гишүүн биечлэн оролцож санал өгөхөөр тусгалаа.



УИХ-ын гишүүн Н.БАТСҮМБЭРЭЛ:

Санал хураалттай холбогдох хариуцлагыг нэмэгдүүлж байгаатай холбоотойгоор гишүүн нэг сарын хугацааны нэгдсэн, байнгын, дэд хорооны нийт санал хураалтын 50-аас дээш хувьд оролцоогүй бол Ёс зүйн дэд хороо гишүүний ажлын албаны цалингаас бусад гишүүний төсвийн нэг сард оногдох санхүүжилтийг олгохгүй байх хариуцлага хүлээлгэх зохицуулалтыг тусгасан юм.

НЭГ ХҮНИЙ ХАНДИВЛАСАН ЦУС ГУРВАН ХҮНИЙ АМИЙГ АВРАХ БОЛОМЖТОЙ



Цусны донорын тухай хууль
Батлагдсан огноо: 2026.05.22

Монгол Улс 1939 онд анх цус сэлбэлтийн тусламж үйлчилгээ үзүүлж ирсэн, 1963 оноос бие даасан нэгж анх байгуулагдсан

2021 оны байдлаар

19,337 цусны донор бүртгэгдсэн

7,837 донор тогтмол цус, түүний бүрэлдэхүүн хэсгээ бэлэглэж байна.

38 нэр төрлийн

103,265 нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэж

61,675 нэгж цус, цусан бүтээгдэхүүнийг эмнэлэгт олгоод байна.




УИХ-ын гишүүн Ж.Чинбүрэн нарын хамт санаачлан боловсруулж, өргөн мэдүүлсэн энэхүү хуулиар цус, цусан бүтээгдэхүүний нөөц, хангамжийн тасралтгүй байдлыг хангах, тус салбарын зохион байгуулалтыг боловсронгуй болгох, улмаар цусны салбар төвүүдийн статус, дэлхий нийтээр баримталж байгаа “нэгдсэн тогтолцоо”-нд үе шаттайгаар шилжүүлэх асуудлыг тодорхой болгох, цусны донор, цус сэлбүүлэгчид тавигдах шаардлага, эрх, үүргийг тогтоох, цус авах, шинжлэх, боловсруулах, хадгалах, тээвэрлэх, хэрэглэхтэй холбоотой харилцааг нарийвчлан зохицуулсан юм.

Цусны донорын тухай хууль:

- Цус сэлбэлт судлалын салбарын эрх зүйн орчин улам боловсронгуй болж, үүний хэрээр цус, цусан бүтээгдэхүүний нөөц, хангамж улам сайжирч, цус сэлбэлт судлалын салбар хөгжин дэвших шинэ боломжууд нээгдэнэ.
- Иргэд эх орондоо дэлхийн жишигт нийцсэн чанартай тусламж, үйлчилгээг хүртээмжтэй авах боломж нэмэгдэнэ.
- Цус сэлбэлт судлалын үйл ажиллагааг зохицуулах удирдлагын тогтолцоо, үйл ажиллагаа шинэ шатанд гарна.
- Цусны донорын сургалт, сурталчилгаа, түүний дотор орон нутаг дахь үйл ажиллагаанд ахиц дэвшил гарснаар эрүүл аж төрөх ёсны талаарх ойлголт сурагч, оюутнаар дамжин өргөжнө.
- Цусны донор, сэлбүүлэгч, эмнэлгийн мэргэжилтэнд тавигдах шаардлага, тэдний эрх, үүрэг тодорхой болохын дээр тэдний нийгмийн халамж, алдаршуулалт, урамшуулал сайжирч, цусны донорын тоо нэмэгдэнэ.
- Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үед цус, цусан бүтээгдэхүүний нөөц, хангамж бүрэн шийдэгдэх нөхцөл бүрдэх аж.

2026 оны байдлаар Монгол Улсад **210 мянга** гаруй донор хүний амь насыг аврах эрхэм үйлсэд нэгдэж байна.




Нэг амьгүй донор **найман хүний амь** насыг аврах боломжтой

Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай бие даасан хууль
Батлагдсан огноо: 2026.05.08



Дэлхийд амьд донороо хамгаалж амьгүй донорыг олноор илрүүлэх алхам руу явж байна. Дэлхийн 93 улс оронд эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээг хийж гүйцэтгэж байгаа бөгөөд 90 орон тус эмчилгээний талаарх бие даасан хууль тогтоомжийг баталжээ.
Үүний нэг нь манай улс болж, “ЭРХТЭН, ЭД, ЭС ШИЛЖҮҮЛЭН СУУЛГАХ ТУХАЙ” анхдагч хуулийг баталсан юм.



Хууль батлагдсанаар:

- Иргэд эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээг эх орондоо хийлгэх боломж нэмэгдэнэ
- Хүйн цус, эд, эсийн сан бий болж, зарим хүнд өвчнийг эмчлэх шинэ боломж нээгдэнэ
- Амьгүй донорын эрх зүйн зохицуулалт тодорхой болж, хүний эрх хамгаалагдана
- Эрхтний болон хүний наймаанаас сэргийлэх хатуу хяналт, хууль эрх зүйн орчин бүрдэнэ
- Шилжүүлэн суулгах эмчилгээний үйл явц нэг мөр, ойлгомжтой эрх зүйн орчинд орно
- Эмч, мэргэжилтнүүдийн шийдвэр гаргалт эрсдэл багатай, хариуцлага тодорхой болно
- Донор, реципиенттэй холбоотой ёс зүйн асуудлыг хуулиар хамгаалсан тогтолцоо бүрдэнэ
- Салбарын хүний нөөц, мэргэшлийг тогтвортой хөгжүүлэх суурь нөхцөл бий болно
- OPT IN / OPT OUT холимог тогтолцоо нэвтэрнэ
- Амьгүй донорын ар гэрт оршуулгын тэтгэмж олгох боломж бүрдэнэ

Иргэдийн аюулгүй байдлыг хангахаар **скүүтер, сурроны** хэрэглээг хуульчиллаа

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай
Батлагдсан огноо: 2026.06.12



Хүн амын хэт төвлөрөл, хотын автозамын түгжрэлээс улбаалан Улаанбаатар хотод нийтийн хэрэглээний цахилгаан дугуй, скүүтер түрээсийн шинэ төрлийн үйлчилгээ бий болоод буй. Иргэдийн хэрэглээний огцом өсөлт, хууль, эрх зүйн хүрээний зохицуулалтгүй байдал нь энэ төрлийн тээврийн хэрэгслээс үүдэлтэй осол гэмтлийн тоо 6 дахин өсөж, амь нас хохирох эрсдэл дагуулж буй.

2026 оны хаврын чуулганаар батлагдсан дээрх хуулийн төсөлд мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгсэл замын хөдөлгөөнд унадаг дугуйтай адил дүрмээр зорчихоор зохицуулжээ.

Энэ төрлийн осол, гэмтлийн тоо



2022 онд **50**
2023 онд **305**
2024 онд **532**
2025 онд **2792**

Харин суррон буюу цахилгаан дугуйг мотоциклтэй адилтган үзэж, холбогдох дүрмийн дагуу зорчих бөгөөд хууль 2026 оны долдугаар сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн юм.

16 нас хүрээгүй хүүхэд замын хөдөлгөөнд оролцсон бол эцэг, эх, асран хамгаалагчийг **200** мянган төгрөгөөр торгоно.

Хуулийн төсөлд:

- 18 нас хүрсэн хүн жолоодож замын хөдөлгөөнд оролцоно
- Унадаг дугуйн зам, эсвэл замын зорчих хэсгийн баруун хөвөөгөөр жолоодно
- Явган хүний гарцаар тээврийн хэрэгслээ түрж гарна
- Жолооч нь сургалтад хамрагдаж, мэдээллийн санд бүртгүүлсэн байна
- Скүүтер, суррон, мопедыг автотээврийн хэрэгслийн бүртгэлд бүртгүүлнэ
- Нийтийн түрээсийн эрхлэгч нь хариуцлагын даатгалд хамрагдсан байна

Гадаадын сайн тамирчдыг Монгол Улсын иргэн болгоё

Харьяатын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл
Батлагдсан огноо 2025.07.09





Дэлхийн улс орнууд спортоор дамжуулан үндэсний үнэт зүйл, амин чанар, бахархлаа улам бэхжүүлж, хүүхэд, залуучуудыг спортын нөлөөгөөр хүсэл мөрөөдөлдөө тууштай, тэвчээр хатуужилтай, зөв төлөвшилтэй болгоход нь ихээхэн анхаарч байна. Түүнчлэн олимпын үзэл санааг түгээн дэлгэрүүлж, спортод өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх үүднээс амжилт гаргах магадлалтай гадаадын иргэнийг өөрийн улсын нэрийн өмнөөс оролцуулах зохицуулалт дэлхийн улс орнуудад ч хүчтэй өрнөж буйг хэлэх нь зүйтэй!

Монгол Улс олимпын түүхэнд жүдо, чөлөөт бөх, бокс, буудлагын спортоор медаль авсан байдаг. Цаашид олимпын наадмын хөтөлбөрт багтах спортын бусад төрөл, ялангуяа багийн спортыг эрчимтэй хөгжүүлэх, хүний нөөцөө бэлтгэх, амжилт гаргах боломжийг нэмэгдүүлэхэд тамирчид, спортын холбоод, клубүүд, зүтгэлтнүүдийн оролцоо, салбарын эрх зүйн орчин нэн чухал байгаа юм. Иймд миний бие УИХ-ын нэр бүхий гишүүдийн хамтаар дээрх хуулийн төслийг боловсруулан өргөн барьсан юм.

Хуулийн төсөлд:



● “Олимпын наадмын хөтөлбөрт багтах спортын төрөлд онцгой амжилт гаргасан буюу гаргах боломжтой гадаадын иргэнийг Ерөнхийлөгч тус хуульд заасан нөхцөлийг үл харгалзан Монгол Улсын харьяат болгож болох”



● Олимпын төрлийн спорт болон багийн спортыг хөгжүүлэх зорилгоор гадаадын дасгалжуулагч, мэргэжилтнийг урьж ажиллуулбал ажил олгогчийн төлбөрөөс чөлөөлөх зохицуулалтыг тусгав.

Нийгмийн даатгалын ерөнхий хууль
Батлагдсан огноо: 2026.07.02

Тэтгэврийн мөнгөн хуримтлал **ҮҮСГЭХ БОЛОМЖ БҮРДЛЭЭ**

УИХ-ын гишүүн А.Ариунзаяа нарын хамт Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг өргөн барьж, Засгийн газраас нэн яаралтай горимоор өргөн мэдүүлсэн Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт хэлэлцэж батлагдлаа.





Хуулийн онцлох зохицуулалтууд:

Суурь тэтгэвэр шинээр олгоно
2027 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн 435 мянган ахмад настанд 100,000–300,000 төгрөгийн суурь тэтгэвэр олгоно.

2033 оноос 10 жилийн цалингийн дунджаар тэтгэвэр бодно
Ингэснээр тэтгэвэр тогтоох тооцоолол илүү бодитой болж, нэрийн дансны даатгуулагчийн тэтгэврийн хэмжээ огцом буурахаас сэргийлэх зохицуулалт хэрэгжинэ.

Тэтгэврийн наснаас хойш ажиллавал тэтгэвэр нэмэгдэнэ
Тэтгэвэр тогтоолгох наснаас хойш үргэлжлүүлэн ажилласан тохиолдолд жил тутамд сарын тэтгэврийн хэмжээ 4 хувиар нэмэгдэнэ. Харин наснаасаа өмнө тэтгэвэр тогтоолговол 4 хувиар буурах зохицуулалттай.

Хувийн тэтгэврийн сангийн эрх зүйн орчин бүрдэнэ
Иргэд сайн дурын үндсэн дээр шимтгэлээ хувийн тэтгэврийн санд төлж, ирээдүйд нэмэлт тэтгэвэр авах боломжтой болно.

Оюутнуудын цагийн хөдөлмөрийг дэмжинэ
Цагийн ажил хийж буй оюутнуудыг нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх зохицуулалтыг тусгалаа.

Жижиг ажил олгогчдыг дэмжинэ
1–5 ажилтантай ажил олгогчийн 3 хүртэлх ажилтны нийгмийн даатгалын шимтгэлийг 36 сарын хугацаанд чөлөөлнө.

Давхар ажил эрхэлж буй иргэдэд уян хатан зохицуулалт бий болно
Давхар ажил гүйцэтгэдэг иргэн өөрөө сонгож, нэг ажлаасаа нийгмийн даатгалын шимтгэл төлөх боломжтой.

Парламентын бодлогын залгамж халаа тасралтгүй **ҮРГЭЛЖИЛНЭ**

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Батлагдсан огноо: 2024.08.23



126 гишүүнтэй парламентын гишүүдээс өргөн мэдүүлж буй анхны хуулийн төслийг 5 гишүүний хамт боловсруулж 2024 оны наймдугаар сарын 23-ны өдөр эцэслэн батлуулав.

Уг хуулиар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлд хэлэлцэн шийдвэрлэх хугацааг нь хуульд тусгайлан заасан асуудлыг Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн жилийн хаврын чуулганаар хэлэлцэн шийдвэрлээгүй бол шинээр бүрдсэн парламентын тухайн асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж болох зохицуулалтыг нэмэхээр болсон юм. Ийнхүү бодлогын шинж чанар, эхэлсэн төсөл хөтөлбөрүүдийг орхилгүй цаашид хэрхэхийг заавал хэлэлцэн шийдвэрлэхээр хуульчилж байна.

УИХ 2023 оны тавдугаар сарын 31-ний өдөр Үндсэн хуулийн хорин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсгийг бүхэлд нь өөрчлөн найруулж “Улсын Их Хурал нэг танхимтай, ***нэг зуун хорин зургаан*** гишүүнтэй байна” гэж тусгав.



Ингэхдээ 2024 оны сонгуулийг холимог тогтолцоогоор буюу гишүүнийг тойргоос, **78**-ыг нь хувь тэнцүүлэх аргаар буюу намын жагсаалтаар сонгосноор түүхэндээ анх удаа **126** гишүүнтэй парламентыг бүрдүүлэв.



УЛСЫН ИХ ХУРЛЫН **ХЯНАН ШАЛГАХ ТҮР ХОРООНЫ** ҮЙЛ АЖИЛЛАГАА ҮР ДҮНД ХҮРНЭ

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль, Батлагдсан огноо: 2026.07.02

Энэхүү хуулийн төслийг дараах зургаан төрлийн арга хэрэгслийн дагуу асуулт, асуулга, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх, мэдээлэл сонсох, тайлан, илтгэл хэлэлцэх, төсвийн хяналт, хяналтын сонсгол, хянан шалгах түр хороо хууль хэрэгжүүлж буй Засгийн газар болон төрийн байгууллагын үйл ажиллагааг хянан шалгах УИХ-ын үйл ажиллагааны үр нөлөөг сайжруулах зорилгоор боловсруулжээ.



Мөн дараах үр дүнд хүрнэ:

- Улсын Их Хурлын хяналт шалгалтын мөрөөр хууль тогтоомжийг боловсронгуй болгох, эсхүл хүчингүй болгох,
- Хэрэгжилтийг хангуулах, эрчимжүүлэх,
- Хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах,
- Холбогдох албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх,
- Шаардлагатай бол Засгийн газрын шийдвэрийг хүчингүй болгох гэсэн үр дүнд хүрэх аж.

УИХ-ын 8 байнгын хороо

- Аюулгүй байдал, гадаад бодлого
- Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн
- Төрийн байгуулалтын
- Төсвийн
- Хууль зүйн
- Хүний хөгжил, нийгмийн бодлого
- Эдийн засаг
- Өргөдлийн байнгын хороо

14 дэд хороотой

- Агаар, орчны бохирдол
- Аялал жуулчлал
- Боловсрол, шинжлэх ухаан
- Бүсчилсэн хөгжил
- Ёс зүй
- Инновац, цахим бодлого,
- Жижиг, дунд үйлдвэрлэл,
- Соёл, спорт, залуучууд,
- Тогтвортой хөгжлийн зорилго,
- Төсвийн зарлагын хяналт,
- Тусгай хяналт,
- Гишүүний халдашгүй байдал,
- Хүнс, хөдөө аж ахуй,
- Хүний эрхийн дэд хороо

Түүнчлэн хууль, тогтоолын хэрэгжилтийг хянах Улсын Их Хурлын үйл ажиллагааг үр дүнтэй болгох, хянан шалгах түр хорооны үйл ажиллагаа илүү чанартай, үр дүнтэй болно гэж төсөл санаачлагчид үзжээ.

ХҮН ТӨВТЭЙ ХУУЛЬ ЗҮЙН БОДЛОГЫН СУУРЬ ТАВИГДАНА

Хууль тогтоомжийн тухай хууль
Батлагдсан огноо 2025.06.27



УИХ-ын 2025 оны хаврын чуулганаар хүн төвтэй, цаг үеийн шаардлагад нийцсэн, иж бүрэн зохицуулалттай, ойлгомжтой хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх чиглэлээр Ажлын хэсгүүдийн санал, дүгнэлт, боловсруулсан хуулийн төслүүдийг хэлэлцэж байна. Тухайлбал, хүн төвтэй хууль зүйн бодлогын суурь Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар тавигдах ёстой. Хууль бүтээх сэтгэлгээг өөрчлөхгүйгээр эрх зүйн хөгжилд хүрэх боломжгүй. Хуулийн төвд хүн орших учиртай. Хууль хэнийг ч үл ялгаж, эрх тэгш хэрэгжиж, хууль дээдлэх ёс бүрэн тогтох ёстой.

“ Өнөөгийн Монгол Улсын нийгмийн харилцааг 1992 оны Үндсэн хуулиар тунхагласан зарчим, үзэл санаа, түүнд нийцүүлэн боловсруулсан хууль тогтоомжоор зохицуулж байна.



УИХ-ын гишүүн
Д.АМАРБАЯСГАЛАН

Өнөөдөр хууль ба журмын зохист харьцаа алдагдсаны улмаас хууль биш, харин журам ноёлж байна. Албан тушаалтны үзэмжээр хандах, авлига, хүнд суртал газар авах хөрс болж байгаа журмуудыг үндсээр нь устгаж, хууль дээдлэх зарчмыг бодит утгаар хэрэгжүүлэх цаг ирсэн.



УИХ-ын гишүүн
Н.БАТСҮМБЭРЭЛ

Хуулийн төсөл боловсруулахдаа тухайн төсөл нь анх батлагдсан хууль болон дагалдаж буй хуулийн төслийнхөө үзэл баримтлал, агуулгад нийцсэн, олон нийтийн саналыг тусгасан, холбогдох тайлбар, үндэслэлийг танилцуулгад тусгадаг байхаар өөрчлөн найруулаа.


Электрон тамхины зохицуулалтгүй хэрэглээг хуульчилж, ирээдүй үеэ хамгаална

Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
Өргөн барьсан огноо: **2025.09.19**



Электрон тамхи нь тамхинаас гарах хэрэгсэл биш бөгөөд өсвөр үеийнхэн, залууст донтох шинэ зам болж буйг ДЭМБ-аас 2021 онд гаргасан “Электрон тамхи ба эрүүл мэнд” тайланд онцолжээ. Янжуур тамхи, электрон тамхины хор хөнөөл яг ижил болохын зэрэгцээ утаа үл үзэгдэх боловч шинэ төрлийн тамхинаас гарч буй хорт элементүүд дам тамхидалтыг үүсгэдэг болохыг эрдэмтэд нотолсон.

> ***Иймд янжуур тамхитай ижил зохицуулалттай болгож, онцгой албан татвар ногдуулах шийдлийг боловсруулав.***



Монгол Улсад тамхинаас шалтгаалсан нас баралт нийт нас баралтын 17 хувийг эзэлж, жил бүр **4300** хүн амь насаа алдаж байна.

Тамхины хэрэглээнээс шалтгаалсан эдийн засгийн алдагдал жил бүр **801 тэрбум** төгрөгт хүрч, дотоодын нийт бүтээгдэхүүний 2.1 хувийг эзэлж байна.

Янжуур тамхи татаж байгаа хүн утааныхаа **80 хувийг уушиг руугаа**, 20 хувийг нь гадагшаа цацдаг бол электрон тамхи 30 хувийг нь уушиг, 70 хувийг нь агаар руу цацдаг байна.

Мэдүүштэй заалтууд:

- Дотор орчинд татаж болохгүй,
- Тусгай зөвшөөрлөөр импортлох
- Тусгай зөвшөөрөлтэй газар зарах
- 21 нас хүрээгүй хүнд зарж, борлуулахыг хориглох

Хуурамч шатахууны эсрэг хуулиар иргэдийн эрүүл мэнд, эд хөрөнгийг хамгаална

Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай, Өргөн барьсан 2025.06.19



2015 онд онцгой албан татварын хувь хэмжээг 400 мянган төгрөг, дизель түлшийг 520 мянган төгрөг болгон тогтоосноос үүдэж, завсрын бүтээгдэхүүний эрэлт нэмэгдэж, уг бүтээгдэхүүнд онцгой албан татвар, тусгай зөвшөөрөл шаардахгүй байгаа нь хуурамч шатахуун үйлдвэрлэх гол шалтгаан болсон юм. Хольцтой шатахуун хэрэглэснээр тоног төхөөрөмж амархан эвдэрч, хоёр жилийн дотор хэрэглээнээс гарахаас гадна машины хар утаанаас үүдэж ялангуяа жирэмсэн эх, хүүхдүүдийн амьсгалын эрхтэн гэмтэж байгааг судалгаа харуулдаг.

Шударгаар татвараа төлөөд явж байгаа олон аж ахуйн нэгжийн эрх ашиг хөндөгдсөн хууль бус үйлдэлд цэг тавьж бидний хэдэн нөхөд онцгой албан татварын тухай хуульд газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн дайвар бүтээгдэхүүнд татвар тогтоох заалтыг нэмж оруулаа.
Ингэснээр хуулийн цоорхойг ашиглан гаараад буй үйлдэл зогсож, агаарын бохирдол 30 хувиар буурах том нөлөөг үзүүлэхээс гадна иргэдийн эд хөрөнгө, эрүүл мэнд хамгаалагдаж, татвараас зугтаах явдал буурч, төсөвт нэмэр болох юм.



Тээврийн хэрэгсэл нь агаарын бохирдлын хоёрдогч том эх үүсвэр бөгөөд утааны

28.9

хувийг үүсгэдэг

Нийслэлийн хэмжээнд

712.992

тээврийн хэрэгсэл хөдөлгөөнд оролцож байна



Хянан шалгах түр хороо байгуулах тухай
Өргөн мэдүүлсэн: 2025.06.27

ОЮУ ТОЛГОЙН БАЯЛГААС ӨР ЗЭЭЛД ТӨЛӨХ БАЙСАН **22 ИХ НАЯД** ТӨГРӨГИЙГ ХЭМНЭЖ ЧАДЛАА

“Оюу толгой бүлэг ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах, хүртэх өгөөжийг нэмэгдүүлэх”-тэй холбоотой “Хянан шалгах түр хороо байгуулах тухай” УИХ-ын тогтоолын төслийг нэр бүхий 89 гишүүний хамт 2025 оны хаврын чуулганаар УИХ-д өргөн мэдүүлсэн билээ.

Хянан шалгах түр хороо гэдэг бол парламентын хяналтын механизмын хамгийн сонгодог жишээ. Дээрх хянан шалгах түр хорооны УИХ-ын тогтоолын хүрээнд:

- **2025.07.02** *Улсын Их Хурлын 2025 оны 62 дугаар тогтоолоор хянан шалгах түр хороо байгуулагдав.*
- **2025.12.08-12** *Хянан шалгах түр хорооноос нотлох баримтыг шинжлэн судлах сонсгол зохион байгуулагдлаа.*
- **2025.12.26** *Хянан шалгах түр хорооны тусгай шалгалт, нээлттэй сонсголын мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай УИХ-ын 120-р тогтоол батлагдлаа.*
- **2026.06.30** *Оюу толгойн хэлэлцээр хийгдлээ*

Оюу толгойн төслийн хамгийн сүүлд төлөгдөх Хувь нийлүүлэгчийн зээлийн хүү **10,5%** байсныг **7,9%** болгож, **2,6%**-иар бууруулаа.
Ур дүнд нь Монголын талын өгөөж **8,7** их наядаар нэмэгдэнэ.

Хэлэлцээрээр

1 Оюу толгой төслийн менежментийн зардлыг 2,2 тэрбум ам.доллар буюу 8 орчим их наяд төгрөгөөр бууруулж Монголын талын өгөөжийг 1,5 тэрбум ам.доллар буюу 5 орчим их наяд төгрөгөөр нэмэгдүүлж чадлаа. Ингэснээр Оюу толгойн баялгаас өр зээлд төлөх байсан 6,2 тэрбум ам.доллар буюу 22 их наяд төгрөгийг хэмнэв. Монголын талын хүртэх өгөөж 2,5 тэрбум доллар буюу 8 орчим их наяд төгрөгөөр нэмэгдэх боломж бүрдлээ.

2 Оюу толгойн хувь нийлүүлэгчийн зээлийн хүүг 7 жил тутам бууруулах цонх нээгддэг байсныг 3 жил тутамд эргэж харж хэлэлцдэг болголоо.

3 Оюу толгойн төслөөс хүртэх ногдол ашгаа энэ оноос авч эхлэхээр тохиролцлоо. Хэлэлцээрүүдийн үр дүн Оюу толгойн баялгаас төлөгдөх 8,4 тэрбум доллар буюу 30 орчим их наяд төгрөгийн зардлыг бууруулж, Монголын талын ирээдүйд хүртэх өгөөжийг 4 тэрбум доллар буюу 13 орчим их наяд төгрөгөөр нэмэгдүүлэх боломж бүрдлээ.

Хүнсний хадгалалт, тээвэрлэлт, худалдааны асуудлыг хуульчилж аюулгүй байдлын тогтолцоог сайжруулна

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Өргөн барьсан огноо 2025.07.04



Хүнсний баталгаат байдал, ханган нийлүүлэлтийн тогтолцоог сайжруулж, хэрэглэгчдийг хүртээмжтэй, шим тэжээллэг, чанартай хүнсээр хангах зорилгоор 13 жилийн дараа ХҮНСНИЙ ТУХАЙ хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг өргөн мэдүүллээ.

Өнөөдрийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Хүнсний тухай болон Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулиудаар зохицуулагдаагүй хүнсний тээвэрлэлт, хадгалалт, худалдаа, хоол үйлдвэрлэл, үйлчилгээ, гадаадын тусламжаар хүнс авах асуудал өнөөдрийн хүнсний аюулгүй байдалд сөрөг үр дагавар бий болгоод байна. Үүнээс гадна хүнсний үйлдвэрлэл эрхлэгчдийн хариуцлагыг дээшлүүлэх, эрдэм шинжилгээний ажлуудын үр дүнг төрийн бодлогод тусгах, эрүүл хүнсний хэрэглээг дэмжих сургалт, сурталчилгааны асуудлыг зохицуулахаар тусгалаа.

Хуулийн төсөл батлагдсанаар:

1. Хүнсний аюулгүй байдлыг хангах тогтолцоо иж бүрэн цогц байдлаар хэрэгжиж, хүнсний баталгаат байдал сайжрах төдийгүй хүнсний экспортын чанар сайжирч, олон улсын зах зээлд өрсөлдөх чадвар нэмэгдэнэ;
2. Хүнсний хяналтын тогтолцоог оновчтой болгосноор хүнсний сүлжээнд бүхэлд нь буюу хөдөө аж ахуйн анхан шатны үйлдвэрлэл, хүнсний үйлдвэр, тээвэр, логистик, гадаад, дотоодын хүнсний худалдаа, хоол үйлдвэрлэл, үйлчилгээ, түгээлт, хэрэглэгчийн хүнсний хэрэглээнд тавих хяналт сайжирна;
3. Хүн амыг шим тэжээллэг, чанартай, баталгаатай хүнсээр хангах боломж нэмэгдэж, халдварт бус өвчлөл буурч, түүнтэй холбогдох зардал багасна;
4. Хэрэглэгч бодит мэдээлэлд тулгуурлан сонголтоо хийх чадвар, дадал төлөвшихөөс гадна хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн хариуцлага дээшилж, хүнсний баталгаа сайжирна;



Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай
Өргөн барьсан огноо: **2026.05.29**

ОРОН НУТГИЙН УДИРДЛАГЫН ТОМИЛГООГ ЗАСАГ ДАРГАД НЬ ШИЛЖҮҮЛЭХЭЭР ТӨСӨЛД ТУСГАЛАА

2020 онд батлагдсан хуулийн шинэчилсэн найруулгад засаг захиргааны нэгж, нутгийн удирдлагын чиг үүргийг давхардалгүй, хийдэлгүй тодорхойлсны дээр төрийн зарим чиг үүргийг төлөөлүүлэн гүйцэтгүүлэх зохицуулалтыг тодорхой тусгасан. Харьяа нутаг дэвсгэртээ төрийн чиг үүргийг төлөөлөн хэрэгжүүлэхдээ Засаг дарга нь төрийн төлөөлөгчийн хувьд эрхлэх асуудлын хүрээний агентлагийн удирдлагыг томилж, чөлөөлөх, хариуцлага тооцох, ажлын төлөвлөлт, түүний гүйцэтгэлд хяналт тавих, чадварлаг төрийн албан хаагчийг сонгон шалгаруулах, урьж ажиллуулах зэргээр удирдлага, зохион байгуулалтын эрхийг нь шилжүүлэх шаардлага үүссэн байна.

Иймд төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагын бодлого хэрэгжүүлэх, төрийн үйлчилгээ, аж ахуйн талаарх чиг үүргийг орон нутагт хэрэгжүүлдэг агентлагуудын удирдлагын томилгоог орон нутгийн Засаг даргад шилжүүлэх боломжтой гэж төсөл санаачлагчид үзэв.



Монгол Улс
21 аймаг
330 сумтай

Орон нутаг дахь байгууллагын захирал, удирдлагуудыг томилох, чөлөөлөх эрхийг Засаг даргад олгох зохицуулалтыг тусгалаа.



УИХ-ын гишүүн Н.БАТСҮМБЭРЭЛ:

Өргөн уудам нутагт иргэдийнхээ өмнө буюу ИТХ-ын өмнө, нөгөө талаас засаг төрийн өмнө буюу ЗГ-ын өмнө үүрэг хүлээж, нэгжийг удирдлагаар хангаж байгаа хүн бол тухайн шатны Засаг дарга байдаг. Бодит байдал дээр томилж, чөлөөлөх эрх байхгүй нөхцөлд аливаа этгээдийг удирдлагаар хангаж үр дүнтэй ажиллуулахад хүндрэлтэй. Тийм учраас орон нутагт үйл ажиллагаа явуулдаг Засаг даргын харьяа 7 байгууллагын удирдлагын томилгоог тухайн шатны Засаг даргад шилжүүлэхээр төсөлд тусгасан.



УИХ-ын гишүүн Н.НАРАНБААТАР:

Мөн хуулийн төсөлтэй холбогдуулан Боловсролын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай, Хүүхэд хамгааллын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн халамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Соёлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Биеийн тамир, спортын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг боловсруулсан.

Зөвшөөрлийн тухай
Өргөн мэдүүлсэн: 2025.12.17

Үндсэн хуульд тунхаглан заасан иргэний эрх, эдийн засгийн эрх, эрх чөлөөг хангах эрхэм зорилгоор дэвшүүлж буй “ЧӨЛӨӨЛЬЕ!” санаачилгын нэг алхам болгож, УИХ-ын дарга, гишүүдийн хамтаар Зөвшөөрлийн тухай хуулийг өргөн мэдүүлсэн.

Энэ хуулийн эрхэм зорилго, үзэл санаа нь: Өөрийн гараар амьдралаа өөд татъя, ашиг орлого олъё гэсэн хүний хүслийг хяссан ЗӨВШӨӨРӨЛ нэртэй ХОРИГЛОЛТЫН системээс ЧӨЛӨӨЛӨХ юм.



ЗӨВШӨӨРӨЛ НЭРТЭЙ ХОРИГЛОЛТ, ХҮНД СУРТЛААС ЧӨЛӨӨЛЖ ИРГЭДЭЭ ДЭМЖИНЭ

Гэвч гэрчилгээ, бүртгэл, тохирол, лавлагаа, тодорхойлолт гэх мэт нэр, зүсийг нь өөрчилж хувиргасан хүнд суртлын тогтолцоо ахин дахин амилах санаархлыг уг үндсээр нь өөрчлөх.

Зөвшөөрөл, мэдэгдлийн хуулийг хэлэлцэн баталснаар иргэд хүссэн цагтаа гутал, дугуй засвар, үсчин, оёдол гэх мэт бизнесээ нээсэн тухайгаа аймаг, дүүрэгтээ мэдэгдэх л үүрэгтэй. Эрсдэл багатай, ахуйн шинжтэй үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл шаардахгүй.

32 төрлийн үйл ажиллагааг энгийн зөвшөөрөлд шилжүүлэхээр тусгасан



УИХ-ын гишүүн,
Ажлын хэсгийн ахлагч
Д.ЭНХТҮВШИН:

Тодруулбал, зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төсөлд зөвшөөрлийн тоог багасгах, ангилал бууруулахаар тусгасан. Тухайлбал, тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх нийт 32 төрлийн үйл ажиллагааг энгийн зөвшөөрөлд шилжүүлэх, эрх бүхий этгээд хуульд заасан хугацаанд энгийн зөвшөөрөл хүссэн өргөдлийн хариуг өгөөгүй бол зөвшөөрөл олгосонд тооцох боломжтой.



УИХ-ын гишүүн,
Ажлын хэсгийн гишүүн
Н.БАТСҮМБЭРЭЛ:

Мөн төсөлд тусгай болон энгийн 20 гаруй зөвшөөрлийг хүчингүй болгох, тухайн аж ахуйн нэгж чөлөөтэй үйл ажиллагаа эрхлэх, зөвшөөрөл олгох, сунгахтай холбоотой дарамтыг бууруулах, зах зээлийн чөлөөт өрсөлдөөнийг дэмжих эрх зүйн орчныг бүрдүүлэхээр оруулж өгсөн байна. Элдэв төрлийн нэртэй алга дарам цаас хөөцөлдөхгүй, албан тушаалтны үүд сахихгүй, оочирлон дугаарлахгүй байх иргэдийн эрхийг хуульчлан хамгаална.



2022 ОНД ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ ШИНЭЧЛЭН БАТЛАГДСАН Ч

1000

ГАРУЙ ЗӨВШӨӨРЛИЙГ

381

БОЛГОЖ ЦӨӨЛСӨН.

Ойн тухай
Өргөн барьсан: 2026.06.04

ОЙ БОЛ ЗӨВХӨН МОД БИШ, НҮҮРСТӨРӨГЧ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, **БИО-ЭДИЙН ЗАСГИЙН ШИНЭ БОЛОМЖ**



Энэхүү хуулийн төсөл нь ойг зөвхөн “модны нөөц” гэж бус экосистем, орон нутгийн амьжиргаа, эдийн засгийн эргэлт, уур амьсгалын үнэ цэнтэй нэгдсэн баялаг гэж харж байгаа юм. Мөн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Ойн тухай хуулийн зорилт нь Монгол Улсын ойг хамгаалах, нөхөн сэргээх, үржүүлэх, ээзэмших, ашиглах, ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэхтэй холбогдсон харилцааг зохицуулж байгаа аж. Харин дээрх шинэчилсэн найруулгын төслийн зорилт нь ойн нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, тогтвортой ашиглахын зэрэгцээ экосистемийн тэнцвэр, биологийн олон янз байдал, эдийн засгийн үр өгөөж, орон нутгийн оролцоог уялдуулахад чиглэсэн.

Монгол Улсын ойн салбар урьдчилсан тооцооллоор **800 саяас 1.4 тэрбум ам.долларын** хэмжээний орлого оруулах боломжтой.



Ойн тухай хуулийн шинэчилсэн найруулгын *ОНЦЛОГ*

- Байгаль хамгаалал, эдийн засаг, орон нутгийн оролцоог нэг дор зангидсан том өөрчлөлт юм.
- Ойг хамгаалах, нөхөн сэргээх, ашиглахыг цогцоор нь зохицуулна.
- Орон нутгийн иргэд, ойн нөхөрлөл анх удаа бодит оролцоотой, ашиг хүртэх боломжтой болно.
- Ой бол зөвхөн мод биш – нүүрстөрөгч, аялал жуулчлал, био-эдийн засгийн шинэ боломж нээгдэнэ.
- Бүх үйл ажиллагаа шинжлэх ухаан, тооллого, үнэлгээнд суурилна.
- Ил тод, цахим системээр ойн мэдээллийг олон нийтэд нээлттэй болгоно.
- Хэт ашиглалт биш, тогтвортой менежмент гол зарчим болно.
- Хамгийн чухал нь “Ойтой нутгийн иргэд” өөрсдөө хамгаалж, ашиг хүртдэг тогтолцоог бий болгох

“Ойн тухай хуулийн шинэчилсэн найруулга нь ойг зөвхөн ашиглах нөөц биш, харин хамгаалалт, нөхөн сэргээлт, экосистемийн үйлчилгээ, нүүрстөрөгчийн үнэ цэнэ, орон нутгийн амьжиргаа, ил тод цахим менежментийг нэгтгэсэн хөгжлийн нөөц.

Түүнчлэн ойтой нутгийн иргэд, ойн нөхөрлөл, хоршооны оролцоо, ашиг хүртэх боломжийг бодитоор нэмэгдүүлж, самар, нүүрстөрөгчийн орлого, гэрээт менежмент зэрэгт орон нутгийн эрх ашгийг илүү хамгаалсан нь энэ төслийн хамгийн том давуу тал.”

Улсын нисэхийн тухай
Батлагдсан: 2026.06.19



АГААРЫН ХӨЛӨГ, **НИСЛЭГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА** ТОДОРХОЙ БОЛЛОО

Улсын нисэхийн тухай хууль нь 2003 онд анх батлагдаж улсын агаарын хөлгөөр нислэг үйлдэх, улсын нисэхийн аюулгүй ажиллагаа болон аюулгүй байдлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулж ирсэн бөгөөд цаг үеийн шаардлагаар зургаан удаа нэмэлт, өөрчлөлт орсон байна.



УИХ-ын гишүүн, Ажлын хэсгийн ахлагч Ч.АНАР:

Шинэчилсэн найруулгаар Зэвсэгт хүчин, Хил хамгаалах байгууллага, Онцгой байдлын байгууллага, Цагдаагийн байгууллагын ашиглаж буй агаарын хөлөг, нислэгийн үйл ажиллагааг нэгдсэн бодлого, зохицуулалтаар хангах эрх зүйн орчныг бүрдүүллээ. Мөн Улсын Их Хурал, Засгийн газар болон цэргийн мэргэжлийн удирдлагын байгууллагуудын чиг үүрэг, хариуцлагын заагийг тодорхой болгосон.



УИХ-ын гишүүн, Ажлын хэсгийн гишүүн Н.БАТСҮМБЭРЭЛ:

Нисэхийн салбарын агаарын хөлгийн бүртгэл, нислэгт тэнцэх чадварын гэрчилгээ, аюулгүй ажиллагааны хяналтын тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэх, нисэх бүрэлдэхүүний мэргэжлийн үйл ажиллагааны зохицуулалтыг боловсронгуй болгох, шаардлагатай тохиолдолд гадаадын мэргэжилтнийг гэрээгээр ажиллуулах эрх зүйн үндсийг тодорхой болголоо.

Хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд дараах зарчмын шинжтэй өөрчлөлтүүдийг оруулжээ.

- Улсын нисэхийн асуудлыг удирдан чиглүүлэх хүрээнд Улсын Их Хурал, Засгийн газрын бүрэн эрх болон Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, цэргийн мэргэжлийн дээд удирдлагын байгууллага, улсын агаарын хөлгийг ээмшигч байгууллагуудын чиг үүргүүдийг нарийвчлан тодорхойлсон;

- Хуулийн үйлчлэлд хамаарах Зэвсэгт хүчин, Хил хамгаалах ерөнхий газар, Онцгой байдлын ерөнхий газар зэрэг байгууллагууд шинээр агаарын хөлөгтэй болж байгаатай холбогдуулан тэдгээрийг нэгдсэн бодлого, удирдлагаар хангахтай холбогдсон харилцааны асуудлыг;

- Улсын агаарын хөлгийг бүртгэх, нислэгт тэнцэх чадварын гэрчилгээ олгох, гадаадын иргэн гэрээгээр үүрэг гүйцэтгэхтэй холбогдсон эрх зүйн зохицуулалтыг;

- Улсын нисэхийн багц дүрмээр зохицуулах харилцааг нарийвчлан зааж, улсын нисэхийн аюулгүй байдал, нислэгийн үйл ажиллагааны хяналт, зохицуулалтын талаарх харилцааг боловсронгуй болгох зэрэг эрх зүйн зохицуулалтыг нэмж тусгасан нь хүчин төгөлдөр мөрдөж байгаа хуулиас онцлогтой болсон гэж үзэж байна.

УЛСЫН ИХ ХУРЛЫН 2025, 2026 ОНЫ ОНЦЛОХ БАЙР СУУРЬ



20-р зууны хөгжлөөрөө үлдсэн сумдыг татан буулгаж, нэгтгэх хэрэгтэй

Эдийн засгийн үр өгөөжийг ярьж байгаа нь зөв. Татаас ихтэй ч, ач холбогдол муутай 20-р зууны хөгжлөөрөө үлдсэн сумдыг татан буулгах, аймгуудыг нэгтгэх хэрэгтэй байна. Монгол Улсад 330 сум, суурин хэрэгтэй юу, 150 байвал яах вэ; 21 аймаг уу, эсвэл хөгжлийн төвөө дагасан 10 аймаг хэрэгтэй юу гэдэгт эдийн засгийн үр ашиг талаасаа аудитын дүгнэлт хийх нь маш чухал байна.

2024.08.20 "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай" УИХ-ын тогтоолын төслийн хэлэлцүүлгээс, АУБХ

Монгол Улс боловсролын салбараа хөгжүүлж байж л урагшилна!

Бидний хөгжих, хөгжихгүйг тодорхойлох гол салбар бол боловсрол. Үүнийг хөгжүүлэхгүйгээр урагшаа алхах тухай бодох ч хэрэггүй. Гэтэл улстөржсөн, намчирхсан, бусдыг бүлэглэн шахсан томилгоо хийдэг байдал газар авчихаад баыйна. П.Наранбаяр сайд олон мянган багш нарыг гүтгэж, урдаас нь мэдэмхийрч болохгүй. Г.Занданшатар сайд та энэ асуудалд анхаарах ёстой!

2025.06.23, Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцүүлгээс, УИХ

Ерөнхийлөгчийн Төв Ази руу явуулж буй бодлогыг үргэлжлүүлэх нь чухал

Тэтгэврийн асуудлаар Казахстантай хийх хэлэлцээр тэнд ажиллаж, амьдарч буй иргэдэд маш чухал тул батлах хэрэгтэй. Уг хэлэлцээр хавар орж ирээд буцсан. Казахстаны сайдтай болж байж Казахстаны хэлэлцээр батлагдах ёстой байж. Мөн ОХУ-ыг ЗХУ байхад нь байгуулсан гэрээг ч шинэчлэх ёстой.

2025.11.04, Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Казахстан Улсын Засгийн газар хоорондын Тэтгэврийн асуудлаар хамтран ажиллах тухай хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийн хэлэлцүүлгээс, АБГББХ

Аймгийн төвүүдэд ногоон санхүүжилт, ногоон орон сууцны зээлийг бий болгох хэрэгтэй

Улаанбаатарт төдийгүй аймгийн төвүүд, томхон сууринуудад ногоон орон сууцны зээлийг бий болгох боломжийг нь маш сайн бүрдүүлж өгмөөр байна. Монгол гэр, амины орон сууцны дулаалга, насжилтыг тооцох, ямар хугацаанд хийх боломжтойг стандартчилах ажлыг холбогдох яамд хариуцаж, Монголбанк зээлийн бодлоготойгоо уях санаачилга гарган ажилламаар байна.

2025.06.17, Засгийн газарт чиглэл өгөх тухай УИХ-ын тогтоолын төслийн хэлэлцүүлгээс, ЭЗБХ

Малчин айлын 6 настнуудад сургуульд дасан зохицох, бэлтгэл үеийн дэмжлэг үзүүлдэг болъё!

“Малчин өрхийн зургаан настай хүүхдийн сургуульд суралцах бэлэн байдал: Амьдралын хэв маягийн харилцан хамаарал” үндэсний хэлэлцүүлэгт оролцож, хүүхэд хаана төрж, ямар соёлд өсөж байгаагаас үл хамааран сургуулийн босго алхахдаа бусадтай ижил түвшинд бэлтгэгдсэн байх, тэгш боломжоор хангагдах нь боловсролын чанарын суурь асуудал болохыг онцлов.

2025.12.03, “Малчин өрхийн зургаан настай хүүхдийн сургуульд суралцах бэлэн байдал: Амьдралын хэв маягийн харилцан хамаарал” үндэсний хэлэлцүүлгээс

Бэрхшээл иргэнд бус, орчинд байдаг тул бодлого тийш чиглэх ёстой!

Манай улсад 111 мянган хөгжлийн бэрхшээлтэй иргэн бий. Үүнээс хөдөлмөрийн насны 89 мянган иргэн байгаагаас ердөө 18 хувь нь хөдөлмөр эрхэлж байна. Иймд тэдний хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, ажлын байрны хүртээмжийг сайжруулахын тулд

- Хүртээмжтэй орчин
- Ажлын байрны бодит дэмжлэг
- Оролцоотой шийдвэр гаргалт гэсэн 3

асуудалд анхаарч, бодлогын түвшинд шийдвэрлүүлэх нь чухал

2025.12.03, Олон улсын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах өдрөөр онцлов

Гишүүдийг Монгол Улсын зээлтэй холбоотой мэдээллээр бүрэн хангах шаардлагатай байна!

Нийт зээлийн 3,6 хувийг дотоод өр эзэлж байна. Зээлдүүлэгч нь хэн болох, юунд зориулагдсан, өрийн баталгаа хаана гарч байна гэзэг бүрэн мэдээллийг УИХ-ын гишүүд сонсох ёстой. Багш, ажилчдынхаа цалинг нэмэгдүүлж чадахгүй мөртөө, өдөрт 10 тэрбумын зээлийн хүү төлөхөөс эхлээд асуудлууд их байна.

2025.10.03, Оюу толгойн бүлэг ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах, хүртэх өгөөжийг нэмэгдүүлэхтэй холбоотой баримт бичиг, үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх Улсын Их Хурлын хянан шалгах түр хорооны хурлаас

Газрын тосны салбарын бодлого нь Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдалд чухал нөлөөтэй

Аливаа гэрээ нэг талаасаа Монгол Улсын эрх ашгийг хамгаалсан, нөгөө талаасаа хөрөнгө оруулалтын орчныг тогтвортой байдлыг хангахад чиглэх ёстой. Иймд газрын тосны салбарын эрх зүйн орчныг тодорхой, ойлгомжтой болгох, бүтээгдэхүүн хуваах гэрээний хэрэгжилтийг сайжруулах, дотоодын боловсруулах үйлдвэрийн хэрэгцээтэй уялдсан бодлого хэрэгжүүлэх чиглэлд анхаарч ажиллаж байна.

2026.06.30, Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанаар Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгээс, ЭЗБХ



Төрийн болон албаны нууцын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл
Өргөн мэдүүлсэн огноо: 2026.03.18

“Албаны нууц”-ыг халж, 882 мэдээлэл ил болно

Төрийн үйл ажиллагаа ил тод бус байх нь иргэдийн мэдэх эрхийг зөрчих төдийгүй авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдэгдэх суурь нөхцөлийг бүрдүүлдэг.

Хуульд “Албаны нууц” гэдэг шалгуурыг тодорхой зааж өгөөгүйн улмаас төрийн байгууллагууд мэдээллээ хэт өргөн хүрээнд нууцлах, иргэдийн мэдэх эрхийг хязгаарлах эрсдэл байсан бол Төрийн болон албаны нууцын тухай хуулийн шинэчлэлээр “албаны нууц” гэсэн зохицуулалтыг хасаж, зөвхөн төрийн нууцтай холбоотой харилцааг хэвээр үлдээхээр хуулийн төсөлд тусгалаа.

Ингэснээр албаны нууцад хамаарч байсан 882 мэдээлэл ил болж, төрийн нууцад хамаарахаас бусад төрийн байгууллагын мэдээлэл иргэдэд нээлттэй болох юм.

Мөн төрийн нууцын жагсаалтыг Засгийн газрын түвшинд бус, УИХ-аар хэлэлцүүлэн баталдаг болох зохицуулалтыг нэмжээ.



Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар томилогдсон даруйдаа 01 тоот албан даалгавраараа нийгэмд шударга ёсыг бэхжүүлэх, авлига, албан тушаалын гэмт хэрэгтэй тэмцэх зорилгын хүрээнд Төрийн болон албаны нууцын тухай хууль тогтоомжийг боловсронгуй болгохыг холбогдох байгууллагуудад үүрэг болгож байв.



УИХ-ын гишүүн Н.БАТСҮМБЭРЭЛ:

Шийдвэр гаргалт хариуцлагатай, ил тод, нээлттэй байх, төрийн үйлчилгээ түргэн шуурхай, хүнд суртлаас ангид байх зарчмын хэрэгжилт хангагдаж, авлига, албан тушаалын гэмт хэрэг буурахад эерэг нөлөө үзүүлэхээс гадна төрийн байгууллага, албан тушаалтан үндэслэлгүйгээр мэдээллийг нууцад хамаарууллах явдлыг таслан зогсоож, үйлдэл гаргахаас сэргийлэх, улмаар төрд итгэх олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэх боломжтой.




Ипотекийн зээлийг **8-14 хувийн хүүтэй олгож**, хүртээмжийг нэмэгдүүлнэ

УИХ-аас байгуулсан ипотекийн зээлийн хөтөлбөрийн хэрэгжилтийг хянан шалгах ажлын хэсгээс зээлдэгчдийн 60 гаруй хувь нь олон байр авсан, хүртээмж муу, хүлээгдэж буй зээлийн хүсэлт 5.5 их наяд төгрөгт хүрсэн зэрэг ноцтой зөрчлүүд илрүүлээд буй юм. Хөтөлбөрт хамрагдсан иргэдийн дийлэнх нь анх удаа бус, харин 2-5 дахь орон сууцаа авсан чинээлэг иргэд байгаа нь хөтөлбөрийн үндсэн зорилгыг гажуудуулаад байсан юм.

Иймд тус хөтөлбөрийг сайжруулж, иргэдийг урт хугацаанд чирэгдүүлэхгүйн тулд зээлийн хүүг 8-14 хувийн хүүтэй, шаталсан олон төрлийн шинэ зээлийн бүтээгдэхүүн санал болгох шаардлагатай гэж Ажлын хэсгээс үзжээ. 2026 онд төрөөс нийт 1 их наяд төгрөгийн санхүүжилт гаргахаар төлөвлөж байгаа бөгөөд зээлийн хүртээмжийг тогтвортой болгохын тулд гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдаас эх үүсвэр татах “Орон сууцны санхүүжилтийн банк”-ыг шинээр байгуулах, зээлийн хүүг олон шатлалтай болгох хуулийн өөрчлөлтүүд УИХ-аар хэлэлцэгдэж байна.

Мөн түүнчлэн эмч, багш болон төрийн албан хаагчдыг орон сууцжуулах тусгай хөтөлбөр, судалгаануудыг салбарын яамнаас хийж байгаа аж.



Өнөөдрийн байдлаар
35-47 мянган иргэн
зээлд хамрагдахаар дугаарлан хүлээж байна.
Жилд дунджаар
9,000 орчим өрх шинээр зээл авдаг.



УИХ-ын гишүүн, Хот байгуулалт, орон сууцжуулалтын сайд Э.БАТ-АМГАЛАН:

Зөвхөн 6 хувийн хүүтэй зээл олгож байгаа нь 4-5 жилийн хүлээлт үүсгэж, иргэд арилжааны банкны 18-аас дээш хувийн хүүтэй энгийн орон сууцны зээлд хамрагдахаас өөр сонголтгүй байгаа. Иймд олон шатлалтай хүү бүхий зээлийн төрөлжсөн бүтээгдэхүүн санал болгох шаардлага үүссэн.



Төрөөс **аялал жуулчлалын хүртээмж**, дэд бүтэц, үйлчилгээний чанарыг цогцоор нь дэмжинэ

Аялал жуулчлалын салбарт ирүүлсэн зээлийн хүсэлтийн нийт хэмжээ 2.3 их наяд төгрөгт хүрч, олгох боломжит эх үүсвэрээс 9.2 дахин давжээ. Энэ нь тус салбарт үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгж, бизнес эрхлэгчдийн идэвх нэмэгдэж, хөрөнгө оруулалтын бодит хэрэгцээ өндөр байгааг илтгэж буй юм. Иймд 2026 онд тус салбарыг бодитоор дэмжих зорилгоор 250 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрийг шийдвэрлэхээр ажиллаж буйгаа Аялал жуулчлалын хөгжлийн дэд хорооны даргын хувиар илэрхийллээ.

Мөн орон нутгаас ирүүлсэн зээлийн эрэлт Улаанбаатар хотоос 2.3 дахин өндөр байгаа нь бүсчилсэн хөгжлийг дэмжих, орон нутагт ажлын байр бий болгох, эдийн засгийн идэвхийг нэмэгдүүлэх чухал боломж болж байна.

Хөнгөлөлттэй зээл нь зөвхөн зочид буудал, жуулчны баазаар хязгаарлагдахгүй. Харин аялал жуулчлалын салбарын суурь дэд бүтэц, хүртээмж, үйлчилгээний чанарыг бүхэлд нь дэмжихэд чиглэж байгаа аж.

Санхүүжилт олгох чиглэлүүд:

- АВТО ЗАМ ДАГУУХ ТҮР БУУДАЛЛАХ ЦЭГ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЦОГЦОЛБОР
- АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЦОГЦОЛБОР
- ЖУУЛЧИН ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ
- АГААРЫН ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ

Аялал жуулчлалын салбарт үйл ажиллагаа эрхлэгчдэд → 10 банкны эх үүсвэрт тулгуурлан | 6% хүүтэй | 6 жил хүртэлх хугацаатай хөнгөлөлттэй зээл олгох

Засгийн газрын 2025 оны 255 дугаар тогтоол **2025.05.21-ний өдөр** батлагдсан бөгөөд 2026.07 байдлаар **42 аж ахуйн нэгжид 86 тэрбум төгрөгийн** зээл олгох шийдвэр гараад байна.



Боловсролын чанар нь сургалтын орчин, багшийн хөгжил, хүүхэд бүрийн суралцах тэгш боломжоос шууд хамаардаг.

Боловсролыг дэмжих **лобби бүлэгт** нэгдлээ

Ядуурлаас гарах ганц зөв гарц нь боловсролдоо хөрөнгө оруулах юм. Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны энэ салбарт ажилласан туршлагатай гишүүд нэгдэж, 2026 оны тавдугаар сарын 28-ны өдөр УИХ дахь “Боловсролыг дэмжих лобби бүлэг” байгуулагдсан юм.

26 гишүүнтэй тус бүлгийн даргаар УИХ-ын гишүүн Ж.Галбадрах, дэд даргаар УИХ-ын гишүүн Н.Батсүмбэрэл нар ажиллаж байна.

Улс төрийн нам харгалзахгүйгээр боловсролын чанар, хүртээмж, хууль эрх зүйн орчин болон багш, ажилчдын нийгмийн баталгааг сайжруулах зорилгоор нэгдсэн энэхүү нөлөөллийн бүлэг нь хуулийн төсөл боловсруулах, төсөв батлуулах, хэрэгжилтэд хяналт тавих замаар ажиллах юм.

Тухайлбал, сургалтын орчны ялгааг бууруулах, багшийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг сайжруулах, боловсролын санхүүжилт, хөрөнгө оруулалтын үр өгөөжийг нэмэгдүүлэх чиглэлд Засгийн газарт чиглэл өгч ажиллах аж.



Монгол Улсад 2025-2026 оны байдлаар 895 ЕБС-д нийт 826.860 хүүхэд, 1426 цэцэрлэгт 256.031 хүүхэд суралцаж байна.

/Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо/

> “2026 онд Монгол Улсын боловсролын салбарт нийт **5.4 их наяд** төгрөгийн нэгдсэн төсөв батлсан нь өмнөх оноосоо **117.0 тэрбум** төгрөгөөр нэмэгдсэн үзүүлэлт болжээ.

Кибер аюулгүй байдлаа **ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН** ТҮВШИНД ХАМГААЛНА

Технологийн эрчимтэй хөгжилтэй зэрэгцэн кибер эрсдэл нэмэгдэж буй энэ үед ойлгомжтой, хэрэгжих боломжтой, иргэний эрхийг хамгаалсан хууль нэн чухал юм.

2021 оны 12 дугаар сарын 17-ны өдөр батлагдсан Кибер аюулгүй байдлын тухай хууль нь үндэсний тогтолцооны суурийг тавьсан боловч технологийн хөгжил, халдлагын төрөл, үндэсний мэдээллийн дэд бүтцийн хамаарал эрс өөрчлөгдсөн өнөөгийн нөхцөлд хуулийн хэрэгжилтийн бодит чадавх, шинэчлэлтийн хэрэгцээг эргэж харах шаардлагатай болжээ.


МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

“Цагаан хэрэм бариад л хаачихдаг байсан халдлагыг одоо хэдийг ч бариад хаах боломжгүй болсон, дэлхий нийтээрээ.”

150
орон кибер аюулгүй байдлыг хангах чиглэлээр бие даасан хууль тогтоомж баталжээ.

Өнөөдөр аль нэг улсын дэд бүтэц, олон нийтийн сэтгэл зүй рүү шууд халдлага үйлддэг болсон нь үндэсний хэмжээний том асуудал болоод буй юм. Иймд халдагч этгээдийн гарал үүслийг нь тогтоогоод, сөрөг арга хэмжээ авах олон улсын жишиг хандлагыг нэвтрүүлж, эрх зүйн хувьд нээж өгөхөөр Ажлын хэсэг хуулийн төсөл дээр ажиллалаа.

ДЭЛХИЙН КИБЕР АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ИНДЕКС

ТЭРГҮҮЛЭГЧ ОРНУУД	МОНГОЛ УЛС
100 ОНОО	56 ОНОО

193 ОРНООС
103
ДУГААРТ ЭРЭМБЭЛЭГДЭЖ БАЙНА.



УИХ-ын гишүүн, Ажлын хэсгийн ахлагч Ч.АНАР:

Хуурамч контент зэрэг нь кибер аюулгүй байдлын асуудал биш. Хиймэл оюун ухаанд суурилсан когнитив дайны үед сөрөн тэсвэрлэхийн тулд хувь хүний мэдээлэл, өгөгдлийг хамгаалах нь улс үндэстний тэргүүлэх бодлого байх ёстой. Иргэний болон төрийн нууцад байгаа мэдээллийг олж аваад, хиймэл оюун ухаанаар боловсруулан иргэд, олон нийтэд нөлөөлж байгаа үйл ажиллагааны эсрэг бид зогсох юм. Бид тэрхүү худал мэдээлэл тараах “түлшийг” нь л хамгаална гэсэн үг.



“АРДЫН НАМ - АРД ТҮМЭНДЭЭ” ИРГЭДИЙН ОРОЛЦООНД ТУЛГУУРЛАСАН БОДЛОГО ШИЙДВЭРҮҮД

БОДЛОГО

ТОМИЛОЛТ



Монгол Ардын Намын
бүлгийн дэд даргаар сонгогдлоо

УИХ дахь МАН-ын бүлэг 2025-2026 онд төсвийн алдагдал болон нийгмийн халамжийн шинэчлэлд гол анхаарлаа хандуулж, багш нарын цалинг шат дараатай нэмэх, “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийг батлах, мөн Засгийн газрын бүтцийн асуудлыг шийдвэрлэх, намын дарга Н.Учралыг Ерөнхий сайдад нэр дэвшүүлж, томилуулах зэрэг томоохон шийдвэрүүдийг гаргасан юм.

Хууль, эрх зүйн шинэчлэлийн хүрээнд мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах байнгын хороодын ажлын хэсгүүдийг байгуулж, эдийн засгийг төрөлжүүлэх Евразийн хэлэлцээр, татварын багц шинэчлэл, эдийн засгийн эрх чөлөөг баталгаажуулсан хуулийн төслүүд дээр ажиллаад байна.

Татварын багц шинэчлэл

- Сард **792 мянган** төгрөг хүртэлх цалин, орлогоос ХХОАТ авахгүй. (2027 оны 1-р сарын 1-нээс)
- 792 мянгаас 2 сая төгрөг хүртэлх орлогод **1 хувийн татвар** ногдуулна. (2028 оны 1-р сарын 1-нээс)
- ААН-ийн орлогын татварын босгыг өөрчилж, 6–10 тэрбум төгрөгийн орлогод **15%**, 10 тэрбум төгрөгөөс дээш орлогод **25%**-ийн татвар ногдуулна.
- Жижиг, бичил бизнесийн хялбаршуулсан татварын босгыг **400 сая төгрөг болгож, 1 хувиар татвар** төлөх боломжийг олгоно.
- Татварын өртэй аж ахуйн нэгжүүдийн банкин дахь дансыг бүрэн хаахгүй, үйл ажиллагаагаа хэвийн үргэлжлүүлэхэд нь зориулж **20-30 хувийг** нь битүүмжлэлгүй үлдээхээр тусгажээ.
- Багш нарын цалинг 2026 оны 01 дүгээр сарын 01-нээс **50 хувиар**, 11 дүгээр сарын 01-нээс **75 хувиар** нэмэгдүүлэх,
- Эрүүл мэндийн салбарын эмч, ажилтнуудын цалинг **15 хувиар өсгөх** шийдвэр гаргаж, 1.1 их наяд төгрөгийн урсгал зардлыг бууруулж зохицуулав.

ЖИЖИГ, БИЧИЛ БИЗНЕСИЙН ХЯЛБАРШУУЛСАН ТАТВАРЫН БОСГЫГ

400

САЯ ТӨГРӨГ БОЛГОЖ,

1%

ТАТВАР ТӨЛӨХ БОЛОМЖИЙГ ОЛГОНО.



УИХ дахь МАН-ын бүлгийн дэд дарга Н.БАТСҮМБЭРЭЛ:

Миний хувьд улс төрийн байгууллагад анхан шатнаас нь эхлэн ажиллаж, нийслэл, дүүргийн түвшинд иргэдийн өдөр тутмын хэрэгцээ, бодит асуудалтай ойр ажиллаж ирсэн. Энэ хугацаанд хуримтлуулсан мэдлэг, туршлагаа Улсын Их Хурлын үйл ажиллагаанд, тэр дундаа бүлгийн бодлогын уялдаа, зохион байгуулалт, шийдвэрийн үр дүнд чиглүүлэн ажиллах болно.

“Гишүүн төвтэй нам-Е4 стратеги” бодлогын хороог ахлан ажиллаж байна



Энэ нь Монгол Ардын Намаас дэвшүүлэн хэрэгжүүлж буй намын шинэчлэлийн бодлого бөгөөд УИХ-ын гишүүн Н.Батсүмбэрэл “Гишүүн төвтэй нам-Е4 стратеги” бодлогын хороог ахлан ажиллаж байна.

Стратегийн дараах 4 үндсэн зарчим дээр тулгуурладаг.

Efficiency (Үр ашиг): ENAM 3.0 цахим платформ ашиглан шат шатны намын санхүүжилтийг цахимжуулж, үр дүнд суурилах.

Engagement (Идэвхтэй оролцоо): Намын анхан шатны байгууллага, гишүүдийн санал бодлыг сонсож, шийдвэр гаргах түвшинд гишүүдийн оролцоог нэмэгдүүлэх.

Empowerment (Эрх мэдэлжүүлэх): Гишүүдийг чадавхжуулах, дэмжих тогтолцоог бий болгох.

Ethics (Ёс зүй): Намын гишүүдийн сахилга бат, ёс зүйн стандартыг дээшлүүлэх.

Энэ хүрээнд гишүүдийн нээлттэй оролцоог хангах, намын үйл ажиллагааг улс орон даяар, салбар нэгжүүдэд танилцуулах ажлууд эрчимтэй хийгдэж байна.



Тухайлбал, “Гишүүн төвтэй нам Е4 стратеги-Ахмадын оролцоо” сэдэвт уулзалтыг өнгөрсөн гуравдугаар сард зохион байгуулж, намын ахмад гишүүд, иргэдтэй нээлттэй ярилцаж, тэдний санал, хүсэлтийг сонсож үйл ажиллагаандаа тусгахаар зорьж байна.



“Ардын нам-Ард түмэндээ”

аян Баянхонгор аймагт

УИХ-ын гишүүн Н.Батсүмбэрэлээр ахлуулсан ажлын хэсэг МАН-ын Удирдах зөвлөлийн Ажлын албанаас зохион байгуулж буй “Ардын нам – Ард түмэндээ” (ENAM 3.0) аяны хүрээнд Баянхонгор аймагт амжилттай ажиллалаа.

Аймгийн төв болон Жинст, Богд, Шинэжинст, Бөмбөгөр, Баянговь, Өлзийт зэрэг сумдын зуун намын гишүүд, дэмжигчидтэйгээ уулзаж Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, МАН-ын хөгжлийн бодлого, “Е4 стратеги”, “Чөлөөлье” санаачилга болон ENAM 3.0 платформын зорилгыг танилцуулсан.

Энэ үеэр намын ахмад гишүүн, буурал багш Л.Баатар, Д.Далхаа нарынхаар зочилж, намын даргын мэндчилгээг дамжуулан үнэтэй зөвлөгөөг нь сонсов.

Ахмад гишүүд, иргэдийн зүгээс олон жил хөдөлмөрлөсөн хүний гавьяа учраас тэтгэврийг бодитойгоор нэмэгдүүлж, ахмадын амьжиргаанд дэмжлэг үзүүлэх, уул уурхайн нөхөн сэргээлтийн асуудалд онцгойлон анхаарч, хариуцлагыг чангатгах, өрхийн хэмжээнд хүнсний ногоо тарих болон жижиг бизнес эрхлэхэд зээл, санхүүгийн дэмжлэг үзүүлэх зэрэг хүсэлт тавихад бодлогын түвшинд анхаарч ажиллахаа илэрхийллээ.



Боловсролын салбарын бүхий л шатанд үр бүтээлтэй ажилласан ахмад багш Л.Баатартай уулзах үеэр



Баянхонгор аймгийн төвийн иргэдтэй уулзах үеэр



Өлзийт сумын иргэдтэй уулзах үеэр



ХАРИЛЦАН ИТГЭЛЦЭЛ, ХҮНДЭТГЭЛ ДЭЭР ТУЛГУУРЛАСАН

ГАДААД ХАРИЛЦАА

- ХАМТЫН АЖИЛЛАГАА
- ТОМИЛОЛТ
- УУЛЗАЛТ

Чингэлтэй дүүрэг болон **Яйзү хотын хамтын ажиллагааны 8 жил**



Чингэлтэй дүүрэг болон Японы Шизүока мужийн Яйзү хот хоорондын хамтын ажиллагаа 2018 оноос эхэлсэн түүхтэй.

УИХ-ын гишүүн Н.Батсүмбэрэл дүүргийн Засаг дарга байхдаа тус хамтын ажиллагааг шинэ шатанд гаргаж, салбаруудыг өргөжүүлэхэд голлох үүрэг гүйцэтгэсэн. Тэрбээр боловсрол, эрүүл мэнд, худалдаа, аж үйлдвэр, гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх зэрэг олон салбарыг хамарсан Санамж бичгийг 2022 онд шинэчлэн зурсан.



2024 онд Яйзү хотын Засаг дарга Накано Хиромичи тэргүүтэй төлөөлөгчид Чингэлтэй дүүрэгт биечлэн айлчилж, хоёр хотын найрамдалт харилцааг бэхжүүлсэн.



Түүнчлэн хоёр талын **8 гаруй жилийн** тууштай түншлэлийг үнэлж, Яйзү хотын дарга Накано Хиромичийг Монгол Улсын төрийн дээд шагнал **“Алтан гадас”** одонгоор шагнахад түүний оруулсан хувь нэмэр, хамтын ажиллагааны үр дүн чухал нөлөө үзүүлснийг онцлох нь зүйтэй.



Яйзү хотод **“Чингэлтэй дүүргийн нэрэмжит гудамж”** албан ёсоор нээгдсэнээр гадаад улсад өөрийн нэрэмжит гудамжтай болсон Монголын анхны дүүрэг болжээ.

Өнөөдрийн байдлаар Чингэлтэй дүүрэг болон Яйзү хотын хамтын ажиллагаа тогтвортой өрнөж, түүхт 8 жилийн ойн хүрээнд илүү өргөн далайцтай үргэлжилж байна. Харилцаа соёл, спортоос гадна хотын дэд бүтэц, бизнесийн шинэ түвшинд гараад байна. Нэн ялангуяа дүүргийн Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төвийн үйлдвэрлэл эрхлэгчид харилцан туршлага солилцож, бараа бүтээгдэхүүн борлуулах, зөвлөх үйлчилгээ авах чиглэлээр хамтарч байна.



2025 оны аравдугаар сард Чингэлтэй дүүргээс шалгарсан **49, 39, 72, 149** дүгээр сургуулийн зургаан сурагч Яйзү хотын сурагч солилцооны хөтөлбөрт хамрагджээ.

Монгол-Австрийн парламент хоорондын хамтын ажиллагаа шинэ шатанд гарна



УИХ дахь Монгол-Австрийн парламентын бүлгийн даргын хувиар Бүгд Найрамдах Австри Улсын Үндэсний Зөвлөлийн гишүүн, тус Зөвлөл дэх Австри-Монголын бүлгийн дарга Маркус Хоферыг 2026 оны зургаадугаар сарын 08-ны өдөр хүлээн авч уулзлаа.

Уулзалтаар хоёр улсын хууль тогтоох байгууллага хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлэх, ардчиллын үнэт зүйлсэд суурилсан найрсаг харилцааг бэхжүүлэх талаар санал солилцож, цаашид хамтын ажиллагааг эдийн засаг, хөрөнгө оруулалт, боловсрол, соёл, аялал жуулчлал, иргэд хоорондын хэлхээ холбооны чиглэлээр өргөжүүлэх боломжийг эрэлхийлэн ажиллахаар тогтов.



Хоёр улс 1963 оны 7 дугаар сарын 1-нд дипломат харилцаа тогтоосон бөгөөд Австри нь Монголын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрсөн барууны хоёр дахь орон юм. Монгол Улс 2003 онд Вена хотод Элчин сайдын яамаа нээсэн.

Бүгд Найрамдах Австри Улсын Холбооны Ерөнхийлөгч Александр Ван дер Беллен Монгол Улсад төрийн айлчлал хийж, “Монгол-Австрийн Хамтарсан тунхаглал” гарган харилцааг өргөжүүлэхээ зарласан.





Худалдааны нийт эргэлт 2024 оны байдлаар **$39.5** сая ам.долларт хүрснээс Монгол Улс **$5.03** саяын экспорт, Австри Улсаас **$34.5** саяын импорт хийжээ.

Унгар улстай хийх эдийн засгийн хамтын ажиллагааг идэвхжүүлнэ





Монгол-Унгарын парламентын бүлгийн даргын хувьд Унгар Улсын Үндэсний Ассамблейн дэд дарга Др. Олах Лайошийг хүлээн авч уулзлаа.

Бидний 76 жилийн найрамдалт харилцаа өнөөдөр эдийн засгийн шинэ шатанд гарах боломж бүрдээд байна. Уулзалтын үеэр худалдааны эргэлтийг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалтын эрх зүйн орчныг тогтвортой болгох чиглэлээр хоёр улсын парламент нягт хамтран ажиллахаар боллоо.

Зөвхөн түүхэн уламжлал бус, ирээдүйн хөгжил, эдийн засгийн бодит үр ашгийг нэмэгдүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллаж байна.

Хоёр орны худалдааны эргэлт тогтвортой өсөж байгаа бөгөөд хоёр талын худалдааны эргэлт сүүлийн жилүүдэд 50 гаруй хувиар өссөн үзүүлэлттэй байна. Унгараас Монгол руу гаргаж буй экспортын гол цөмийг эм, эмийн бүтээгдэхүүн эзэлдэг.



Эдийн засгийн хамтын ажиллагааны бодит илэрхийлэл болсон “Байдрагийн усан цахилгаан станц” төслийг Засгийн газраас 2026 оны 5-р сард “төр, хувийн хэвшлийн түншлэл”-ийн хүрээнд хийхээр шийдвэрлэж, барилгын ажил 53 сарын хугацаанд үргэлжлэхээр тооцоолжээ.



Унгар Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд **Обрущанский Борбала**

Миний бие элчин сайдаар томилогдсоноосоо хойш хоёр орны худалдааны эргэлтийг нэмэгдүүлэх чиглэлд онцгой анхаарч ажилласан. Үүний үр дүнд өнгөрсөн гурван жилийн хугацаанд Унгараас Монгол руу экспортолсон барааны хэмжээ 120 хувиар өссөн. Цаашид Унгарын эмийн худалдаа, шинэ эм бэлдмэлийг Монголд нэвтрүүлэх нь ч ач холбогдолтой хэмээн харж байна.

Монгол-Киргиз хоёр орны найрамдалт харилцаа шинэ түвшинд хүрнэ



Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техник, соёлын хамтын ажиллагааны Монгол, Киргизийн Засгийн газар хоорондын комиссын V хуралдаан 2025 оны 6 дугаар сарын 26, 27-ны өдрүүдэд Бүгд Найрамдах Киргиз Улсын нийслэл Бишкек хотод болж, миний бие парламентын бүлгийн гишүүдийн хамт оролцоод ирлээ.

Хуралдааны гол зорилго хоёр улсын худалдааны эргэлтийг нэмэгдүүлэх тул бид нэн түрүүнд Монгол Улсаас нийлүүлэх мах, махан бүтээгдэхүүнд ногдуулах хорио цээрээ цуцлах хүсэлтийг тавьсан юм.

Харин Киргиз Улсаас жимс жимсгэнэ, хүнсний ногоо нийлүүлэх, улмаар манай улсад хүлэмжийн аж ахуйг өргөжүүлэхэд хамтран ажиллах саналыг тавьснаар талууд хөнгөн үйлдвэрийн салбарт хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж, эцсийн бүтээгдэхүүнээ бусад зах зээлд нийлүүлэхийн зэрэгцээ Улаанбаатар-Бишкек чиглэлийн шууд нислэгийг сэргээх, авто замын коридор, шинэ маршрут бий болгох, бараа бүтээгдэхүүний туршилтын тээвэрлэлтийг эхлүүлэхээр боллоо.

Монгол, Киргиз хоёр улс 1992 оны 4-р сарын 22-нд дипломат харилцаа тогтоож, 33 жилийн турш бүх салбарт хамтран ажилласнаар худалдааны эргэлт 8 сая ам.долларт хүрчээ.





Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх, Бүгд Найрамдах Киргиз Улсын Ерөнхийлөгч С.Н.Жапаров нар “Найрсаг харилцаа, хамтын ажиллагааг гүнзгийрүүлэх тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Киргиз Улсын Хамтарсан тунхаглал”-д гарын үсэг зурж байв.



УНШДАГ ХҮҮХЭД ХӨГЖДӨГ

Ирээдүйг хамтдаа бүтээе

Хүүхдийн унших дадал, суралцах орчин, боловсролын бодлогыг дэмжсэн санаачилга.



23-р сургуулийн 3100 сурагч, 150+ багш, ажилтан шинэ спорт цогцолборыг ашиглах боломжтой болно.



Унших дадал



Суралцах орчин



Боловсролын бодлого



УИХ дахь Боловсролыг дэмжих лобби бүлгийн дэд дарга

“Чанар, хүртээмж, багшийн нийгмийн баталгааг дэмжин ажиллаж байна.”



114 2026 онд сурагчдын бүтээсэн бүтээл, контент

10,000+ 3 жилийн хугацаанд уралдаанд оролцсон сурагчдын тоо

1 САЯ Цахим орчин дахь хандалт давхардсан тоогоор